

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "ЭКО-ЭРҮҮЛ ДҮҮРЭГ" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2023 ОНЫ БИЕЛЭЛТ

2023 он 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ													
1.1. Ногоон байгууламж													
1.1.1 Нийтийн эзэмшлийн талбайд эко цэцэрлэгт хүрээлэнг бий болгож иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Нийтийн эзэмшлийн талбайд бичил цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНААХ	ТҮТ, Хан-Уул Агро, Хан-Тээвэр ОНӨААТҮГ Хороод	Нийслэл, Дүүргийн төсөв	3,200	8 бичил цэцэрлэгт хүрээлэн, 168 тоглоомын талбай.	2-оос доошгүй бичил цэцэрлэгт хүрээлэн, 4-өөс доошгүй тоглоомын талбай байгуулсан байна	800.0	УБЗАА 360.00 НОНХС 192.0 ДТХО 1529.1 ДОНХС 553.4	Бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт: Хан-Уул дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 5 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил шинээр, 4 байршилд засварлаж шинэчлэн тохижуулах ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс: Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 10, 12, 14-р хороонд шинээр хэрэгжүүлсэн 3 бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил бүрэн хэрэгжиж алслагдсан бүсийн иргэд агаарлах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин бүрдсэн бол 1-р хороонд хэрэгжиж буй бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын явц 60 хувь, 5 дугаар хороонд хэрэгжиж буй бичил цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын явц 15 хувьтай, тус тус он дамжин хэрэгжих бөгөөд 2024 оны 2-р улиралд ашиглалтад орно. Засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд 1-р хорооны дүүргийн өндөрлөг орчмын засвар тохижилт, 8-р хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, 10-р хорооны 7-р байрны гадна талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнгийн засварын ажил хэрэгжиж дууссан, 2-р хорооны ажилчны алдар талбайн засвар шинэчлэлтийн ажлын явц 80 хувьтай хэрэгжиж байна. Тоглоомын талбай, тохижилтын ажил: Дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13 байршилд тоглоомын талбай шинэчилж, тохижуулахаар төлөвлөснөөс 3-р хорооны хүүхдийн сэргээн засах 4-р төв, 5-р хорооны 29-р цэцэрлэг, 7-р хорооны 73-р цэцэрлэг, 12-р хорооны Био салбар эмнэлгийн гадна талбай, 18-р хороо, 29, 30-р байр, 19-р хороо, 27/1 байр, 20-р хороо, ЭМТ-ийн гадна талбай, 12-р хорооны Био салбар эмнэлгийн гадна талбай, 22-р хороо, Зайсангийн автобусны зогсоолын тохижилтын ажил тус тус хэрэгжиж дууссан. 10-р хороо, 60/2-р байр, 13-р хороо 144 дүгээр цэцэрлэг, 14-р хороо 59-р сургуулийн гадна талбайн тохижилтын ажил тус тус 85 хувийн гүйцэтгэлтэй, 1-р хороо, Наран хотхон 8, 18, 20, 21-р байрны гадна талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгч шалгарч зураг төслийн ажил хийгдэж байна. Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор тохижилтын ажлыг 2024 оны 4-р сард эхлүүлэхээр шийдвэрлэсэн. 19-р хороо, 75, 80-р байрны гадна тоглоомын талбайн гүйцэтгэгч шалгаруулах шатанд байна.	100%
	2	Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх аян зохион байгуулна.	2021-2024	ТНААХ	НЗБ-ууд	-	-	29 байршилд тоглоомын талбай, 6 байршилд цэцэрлэгт хүрээлэн 7175м2 явган зам болон 1600м/урт дугуйн замыг хийж гүйцэтгэсэн.	"Манай хороо - Миний гудамж" аяныг зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоотойгоор тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.	-	-	Аяны хүрээнд тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг 8.4 га талбайгаар нэмэгдүүлж, сул шороон хөрс бүхий 2.4 га талбайг зүлэгжүүлж, 75424 ширхэг мод, бут сөөг шинээр, 965 ширхэг мод, сөөг нөхөн тарьж, 24192.8 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлж, 5329.1 м.кв талбайд цэцгийн мандал байгуулж, 9224.1 м.кв явган хүний зам, талбайг засварлан шинэчилж, 3 байршилд бичил цэцэрлэг байгуулж, 11 байршилд иргэд олон нийтэд зориулсан тоглоомын талбай, амралтын талбайг байгуулж, ашиглалтад орууллаа. Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хог тээврийн 16 машинаар парк шинэчлэлт хийж, нийтийн эзэмшлийн гудамж талбайн 14347.8 тн хог хаягдал, 80.3 тн шарилжийг цэвэрлэж, 12099 нүхэн жорлон, 5732 бохирын цооног болон 596011 м.кв талбайг ариутгаж, халдваргүйжүүлж, хүнд металлын бохирдолтой 10 га талбайг нөхөн сэргээсэн. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 95 аж ахуйн нэгж, байгууллага, 509 өрх төвлөрсөн дулаан холбогдох, цахилгаан халаалтад шилжих замаар яндангийн тоог бууруулсан. Аяны нэгдсэн шалгаруулалтаар шилдэг тохижилттой гэр хороо номинацийн нэгдүгээр байранд 13 дугаар хороо, тусгай байранд 6, 16 дугаар хороо, шилдэг тохижилттой орон сууц хороо номинацийн 3 дугаар байранд 3 дугаар хороо, шилдэг хог тээврийн байгууллага номинацийн 2 дугаар байранд "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ, тусгай байранд "Хан-Уул Агро" ОНӨААТҮГ, шилдэг зам цэвэрлэгээний байгууллага номинацийн нэгдүгээр байранд Охь мандал ХХК, шилдэг орон сууцны контор номинацийн нэгдүгээр байранд Хайспийд ХХК, тусгай байранд Хүннү хотхон ХХК, шилдэг сууц өмчлөгчдийн холбоо номинацийн тусгай байранд Цэнгэлдэх өргөө СӨХ тус тус шалгарсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	3	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийг тоолж, бүртгэж мэдээллийн сан үүсгэж, баяжуулж ажиллана.	2021-2024	ТНААХ	Хороод	Дүүргийн төсөв	10	-	Шинээр хийгдсэн ногоон байгууламжийг бүртгэжүүлж, мэдээллийн сангийн баяжилтыг 75% - д хүргэнэ.	100.0	-	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас газар зүйн мэдээллийн системд суурилсан ногоон байгууламжийн мэдээллийн сан байгуулах ажлыг хэрэгжүүлсэн бөгөөд тус мэдээллийн санд 2018 оны нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тооллогын дүн буюу 530864.73 м.кв зүлэгт талбай, 6023 ширхэг навчит мод, 4026 ширхэг шилмүүст мод, 6906 бут, 13,516 урт метр ургамлан хашлагын тоон мэдээллийг бүртгэсэн байна. 2018 оноос хойш нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тооллого хийгдээгүй. 2023 онд Ногоон байгууламжийн хяналтын "Ногоон Агула" ТББ-тай хамтарч Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээтэй 9 байгууллагын хариуцдаг нийтийн эзэмшлийн 28 гудамж, талбайн ногоон байгууламжийн бүртгэл, тооллогоор 260,869 м.кв зүлэгт талбай, 21639 ширхэг мод, бут, 18959 урт метр ургамлан хашлагыг бүртгэсэн. Хот нийтийн аж ахуйн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, чиг үүргийн хамаарлыг оновчтой хуваарилах ажлын хүрээнд ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт дүүрэгт шилжсэнтэй холбогдуулан 2024 онд ногоон байгууламжийн тооллого, бүртгэлийн ажлыг зохион байгуулж, мэдээллийн санг шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100%
1.1.2 Туул, Дунд голыг түшиглэн иргэд 4 улирлын турш амарч, зугаалах зориулалт бүхий тохилог орчныг бүрдүүлнэ.	4	Туул, дунд голын дагуу байршилд иргэдийн амарч, зугаалах бус байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНААХ	ТҮТ, Хан-Уул Агро, Хан-Тээвэр ОНӨААТҮГ Хороод	Нийслэл, дүүргийн төсөв	3,000	3 амралт зугаалгын бус байгуулсан.	1-2 байршилд амралт зугаалгын бус байгуулсан байна.	373.8	257.2 БХОЦ Зардал 204.5 Гадаадын хөрөнгө оруулалт	Дүүргийн 13 дугаар хорооны 7 дугаар хэсэг Туул гол дагуу "Төгсгөчдийн төгөл"-ийн 1.2 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 1950 ширхэг суулгац, 299 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, усалгаа, арчлалт хамгаалалтыг хийсэн. Мөн Баруун шинэ эх үүсвэрийн төслийн барилга угсралтад өртөх Биокомбинат, Шувуун фабрикийн нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн 199 дүгээр хэсэглэл, Туул голын дагуу 3 га талбайд 10,255 ширхэг мод тарьж ойжуулалт хийсэн. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд 100 га талбайг ойжуулах ажлын хүрээнд, 2023 онд "В" хэсгийн 4.2 га талбайд шинээр 8328 ширхэг мод, бут, сөөг тарих ажлыг төрийн байгууллага, ОУБ, иргэдийн оролцоотойгоор хийж гүйцэтгэлээ. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Улсан хотын Нам гү дүүрэг хамтын ажиллагааны хүрээнд 107.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1494 ширхэг мод, бут, сөөг тарьж хүлээлгэн өгсөн. Дүүргийн 4, 5, 6, 7, 8, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 2022-2031 онд 5 үе шаттайгаар 149 га талбайд хэрэгжих Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн /Family Garden/ төсөл зураг төсөл боловсруулагдаж, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх шатанд хэрэгжиж байна. Дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу 22 дугаар хороонд Туул голын эрэг дагуу үерийн эрсдэлтэй бүсэд байрлаж байсан 28 айлыг нүүлгэн шилжүүлж, 5000м2 талбайг чөлөөлөх ажлыг зохион байгуулсан бөгөөд тус талбайд дүүргийн төсвийн хөрөнгөөр олон нийтэд зориулсан цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар зураг төсвийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан. Батлагдсан зураг төсвийн дагуу 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	100%
1.1.3 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5	"Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилт, үр дүнг тооцно.	2021-2024	ТНААХ	ТҮТ ОНӨААТҮГ Хороод	Дүүргийн төсөв	200	-	Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувь.	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/70 дугаар захирамжаар "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Дэд хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн 4 зорилт 17 арга хэмжээний 2023 оны хэрэгжилт 98 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Үүнд; Бүрэн хэрэгжсэн-13, Хэрэгжих шатанд (30%)-2, Хэрэгжээгүй-2 арга хэмжээ байна.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)			
	6	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор "Бүх нийтээр мод тарих өдөр" арга хэмжээг зохион байгуулна.	2021-2024	ТНААХ	Хороод	Дүүргийн төсөв	160	Бүх нийтээр мод тарих арга хэмжээг 5, 10 дугаар сард зохион байгуулж, 21,841 ш мод бут сөөг тарьсан.	Бүх нийтээр мод тарих 2 удаагийн арга хэмжээгээр 20,000-аас багагүй мод бут сөөг тарина.	444.7 БХОЦ Зардал	620.7	53.1 УБЗАА	<p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хан-Уул дүүрэгт 5 бүлгийн 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.</p> <p>"Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг нийтийн эзэмшил, хязгаарлагдмал болон тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2 удаа зохион байгуулж, дүүргийн хэмжээнд 2023 онд 75424 ширхэг мод, бут сөөгийг шинээр тарьж, 965 ширхэг мод, сөөг нөхөн тарьсан.</p> <p>Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 14 дүгээр хорооны Айцын аманд 4.2 га, 13 дугаар хороонд Туул гол дагуу 1.2 га талбайд хамгаалалтын ойн зурвас, Биокомбинат, Шувууны эх үүсвэрийн талбай дахь ус хангамжийн баруун шинэ эх үүсвэрийн төслийн барилга угсралтын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх 3 га талбайд татмын ойжуулалт хийх зорилгоор нийт 8.4 га талбайд БНСУ-ын Нам дүүрэг, дүүргийн төсөв, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр шинээр 22,424 ширхэг, Айцын амны ойжуулалтын талбайд нөхөн тарилтаар 1013 ширхэг мод, сөөг тарьж, усалгаа арчлалт хамгаалалт хийсэн. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн улиасны хэлбэржүүлэлтээс гарсан улиасны 6500 ширхэг модоожсон мөчрийг Агропаркийн талбайд суулгасан.</p> <p>"Ногоон хот – Иргэний оролцоо" аяны хүрээнд 2023 онд 1895 өрхтэй хамтарч 18450 ширхэг, 1, 3, 4, 5, 6, 7, 8, 13, 15, 18, 19, 21 дүгээр хорооны 20 аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоод шинээр 899 ширхэг мод, сөөгийг тарьж, хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.</p>	100%
	7	Цэцгийн үрсэлгээ хийх, нийтийн эзэмшлийн талбайд цэцгийн мандал байгуулна.	2021-2024	ТНААХ	ТҮТ, Хан-Уул Агро, Хан-Тээвэр ОНӨААТҮГ Хороод	Дүүргийн төсөв	200	149,100 цэцгийн үрсэлгээг бойжуулж, нийтийн эзэмшлийн талбайг чимэглэсэн.	200,000-аас доошгүй цэцгийн үрсэлгээг бойжуулж, нийтийн эзэмшлийн талбайг чимэглэнэ.	100.4 ДТХО	100.4	210.0 УБЗАА	<p>Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/77 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нэг наст гоёл чимэглэлийн цэцгийг үрсэлж, 1, 2, 6, 8, 11, 12, 13, 14, 15, 16, 19, 20, 22 дугаар хорооны 28 байршлын 3993 м.кв талбайд 332,370 ширхэг цэцэг тарьж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол гүйцэтгэж ажилласан.</p> <p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, ногоон байгууламжийн мэргэжлийн байгууллагуудтай хамтарч 8, 15, 16, 21, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайн 7 байршилд гоёлын цэцгэн байгууламж хийж, 147,250 ширхэг цэцэг тарьсан.</p>	100%
Шаардагдах төсөв							6,770				1,994.9	3,905.3		
1.2. Агаар, орчны бохирдол														
1.2.1 Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	8	Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.	2021-2024	ТНААХ	ХХҮХ, Хороод	-	-	3 хангамжийн бааз, 57 борлуулалтын цэг байгуулсан.	1 хангамжийн бааз, 55-аас доошгүй борлуулалтын цэг ажиллуулна.		-	80.0	<p>Дүүргийн хэмжээнд 2023 оны галлагааны улиралд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 23 дугаар хороодод сайжруулсан шахмал түлшний 50 борлуулалтын цэг ажиллаж, хэрэглэгчдийг 30,659.9 тн сайжруулсан түлшээр хангасан. Түлшний нийлүүлэлт, түгээлтэд тогтмол хяналт тавьж, нөөцийн мэдээллийг өдөр тутам гаргаж ажиллаж байна. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 9, 10, 12, 13, 21 дүгээр хорооны 10 байршлын 13 агуулахад 17131 тн сайжруулсан түлш нөөцөлсөн.</p>	90%
1.2.2 Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно.	9	Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ	2021-2024	ТГУХ, ТНААХ	БХ	Улсын төсөв	1,009	Төвлөрсөн дулаанд холбогдоогүй төрийн өмчийн 11 халаалтын зуух.	1-ээс доошгүй халаалтын зуухыг төвлөрсөн дулаанд холбоно.		-	1,170.0 Гадаадын хөрөнгө оруулалт	<p>Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийн удирдах нэгжтэй хамтран Цэвэр агаар төслийн хүрээнд 1,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий "Хан-Уул дүүргийн 6 дугаар хороо орчмын 6 хэрэглэгчийг төвлөрсөн ус, дулааны шугамд холбох" төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, төслийн хүрээнд ус дулаан дамжуулах төвийн барилга угсралт, дулаан болон цэвэр усны шугам хоолой татаж угсрах ажил бүрэн хийгдсэнээр "Хоёулаа миний хүү" ХХК-ийн уурын зуухнаас халаалт авдаг 6 дугаар хорооны байр, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, дүүргийн Нэгдсэн эмнэгийн амбулатор, Шуудан холбоо, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн хэлтсийн байрууд инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож халаалтын уурын зуухны ажиллагааг зогсоосон.</p>	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	10	Агаарын бохирдлыг бууруулах, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Цэвэр агаар – Цэлмэг тэнгэр" арга хэмжээг бусчлэн зохион байгуулна.	2021-2024	ТНААХ	Хороод	Дүүргийн төсөв	20	1 арга хэмжээ зохион байгуулсан.	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 3 төрлийн зөвлөмж сэрэмжлүүлэг тараана.	5.0		Дүүргийн нутаг дэвсгэрт цахилгаан хийн халаалт, дулаалга үйлдвэрлэл импортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 9 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран 2023 оны 06 дугаар сарын 17-ны өдөр "Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологийн үзэсгэлэн худалдаа" арга хэмжээ зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Корея Кабель ХХК, Мега хет ХХК, Мөнхийн амар дулаан ХХК, Бурханы гал ХХК, Цахилгаан халаалт үйлдвэрлэгчдийн холбоо, Тасума ХХК, Дулаалга үйлдвэрлэгч Гэгээн өргөө ХХК, Голден блок үйлдвэрлэгч, Сайжруулсан зуухны Роял өвшн ХХК, ХААН банкны ногоон зээл хариуцагч, Янгир хайрхан ХХК-ийн хүнсний худалдаа зэрэг 9 байгууллага, 12 хорооны 16,000 гаруй иргэд оролцсон. Гэр хорооллын 15 хороодын цахим хаягаар өдөрт 3 удаа Угаарын хийн хорлогоос урьдчилан сэргийлэх 6 төрлийн зөвлөмж мэдээллийг тогтмол түгээн 2023 оны 1, 2 дугаар сард зохион байгуулсан "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" 2 удаа нэгдсэн арга хэмжээнд, нийт 2980 иргэнийг хамруулж, гэр хорооллын 17000 гаруй өрхөд 4 төрлийн 26000 гаруй гарын авлага, зөвлөмж хүргүүлсэн.	100%
	11	Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна.	2021-2024	ТНААХ	Хороод	-	-	Ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуухыг тоолж "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" цахим мэдээллийн системд бүртгэсэн.	Эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогыг 1 удаа зохион байгуулж мэдээллийн сан"-г шинэчилсэн байна.	-		Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1561 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүртэл хугацаанд явуулж, 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 16,228, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 705 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 53 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан. Дүүргийн хэмжээнд 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 16,228 зуух тоологдсон нь өмнөх онтой харьцуулахад 862 буюу 5%-иар буурчээ.	100%
1.2.3 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зэрэг мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулна.	12	Гэр хорооллын айл өрхүүдийг угаартах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл хүргэх ажил зохион байгуулна.	2021-2024	ТНААХ	Хороод	-	-	Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөв галлагааны чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэх ажлыг 6 удаа зохион байгуулж, гэр хорооллын 17,464 өрхийг хамруулсан.	Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг 1-2 удаагийн давтамжтай хүргэх ажлыг зохион байгуулж, 16,000-аас доошгүй өрхийг хамруулна.	-	27.1	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1349, А/1357 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжаар Онцгой байдлын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар, Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн бүрэлдэхүүнтэй Шуурхай штаб 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ныг хүртэл хугацаанд ажиллаж, сайжруулсан түлшний нөөц, түгээлт, борлуулалт, угаарын хийн хордлогын дуудлага, нөхцөл байдлын талаар өдөр бүр 2 удаа Төв штабд мэдээлэл хүргүүлж ажилласан. Шуурхай штаб ажиллах хугацаанд 40 иргэн угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандан 31 иргэн тусламж авч буцсан, 9 иргэн хэвтэн эмчлүүлсэн. Гэр хорооллын 15 хороодын цахим хаягаар өдөрт 3 удаагийн давтамжтай Угаарын хийн хорлогоос урьдчилан сэргийлэх 6 төрлийн зөвлөмж мэдээллийг тогтмол түгээж, 2023 оны 1, 2 дугаар сард зохион байгуулсан "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" 2 удаагийн нэгдсэн арга хэмжээнд, нийт 2980 иргэнийг хамруулж, гэр хорооллын 17000 гаруй өрхөд 4 төрлийн 26000 гаруй гарын авлага, өгч зөвлөмж хүргүүлсэн. Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Таван толгой түлш ХХК-тай хамтран 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны өндөр настан ганц бие, олон хүүхэдтэй зэрэг угаартах эрсдэл бүхий 948 өрхөд "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, угаар мэдрэгчээ зөв ажиллуулах, зууханд дулаан баригч бортого суурилуулах" талаар сургалт зохион байгуулсан. Мөн нийт 16228 өрхөөс судалгаа авч, угаарын хийн мэдрэгчгүй байсан 1969 өрхийг 100 хувь угаар мэдрэгчтэй болгож, 9, 10, 12, 14 дүгээр хорооны өндөр настай 566 иргэний зууханд дулаан баригч бортого суурилуулж, зорилтот бүлгийн 103 өрхөд угаар мэдрэгч олгосон.	100%
1.2.4 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	13	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	2021-2024	ТНААХ	Хороод	Улсын төсөв	1,407	350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн.	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 400-аар нэмэгдүүлнэ.	-		Кувейтын ам, Жаргалантын ам, Айцын даваа зэрэг газруудад авто зам дагуу байрлуулсан ил задгай 9 нүхэн жорлонг буулгаж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар хэрэгжүүлж буй Туул гол орчмын хөрсний бохирдлыг бууруулах эко нойлын гүйцэтгэгчээр "Оргил-Өргөө" ХХК шалгарч 8, 9, 10 дугаар хороодод нийт 551 эко нойл барихаас 534 ширхэг нойлын нүх ухаж, 164 нүхэнд кольцо суулган 18 ширхэгт нь бүхээг тавьж ашиглалтад оруулсан. Дүүргийн хэмжээнд 2022 оны мөн үед гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэмчилтгүй 1304 ширхэг нүхэн жорлон байсан бол энэ жил 1523 болж 219 ширхэгийг нэмэгдсэн байна.	70%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	14	Нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	2021-2025	ТНААХ		Дүүргийн төсөв	266	13496 нүхэн жорлон, 8042 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн.	13855 нүхэн жорлон, 8340 бохирын цооногийг 100% ариутгаж халдваргүйжүүлсэн байна.	165.0	165.0	Хороодоос ирүүлсэн бохирын цооног, нүхэн жорлонгийн судалгааг үндэслэн дүүргийн Засаг даргын 2023 оны А/196 дугаар захирамжийн дагуу дүүргийн гэр хорооллын айл өрхийн 12,099 нүхэн жорлон, 5732 бохирын цооног ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулсан.	90%
Шаардагдах төсөв							2,702			170.0	1,442.1		
1.3 Хүнс, хөдөө аж ахуй, инновац													
1.3.1 Дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих "Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	15	"Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлж, тарвасын тариалалтыг дэмжин ажиллана.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ	12-14-р хороод	Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж	-	Зуны 3000м2 талбай бүхий хүлэмжид тариалж нийт 1.0 тн ургац хураан авч байна.	Хүлэмжийн талбайг 0.7-оос доошгүй га-аар нэмэгдүүлнэ.	2.8	3.1	Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих чиглэлээр: Дүүргийн 2021-2024 онд хэрэгжих "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг баталж, хүлэмжийн аж ахуй эрхэлж буй 32 аж ахуйн нэгж, 155 иргэнийг газар тариалангийн нэгдсэн санд бүртгэж, тариалалт, арчлалт, ургац хураалтын явцад хяналт тавьж, дэмжлэг тусалцаа үзүүлж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хүлэмжийн аж ахуйн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2023 оны "Дэмжлэг үзүүлэх тухай" А/190 дүгээр захирамжийг баталж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлсэн. • Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран 6 удаагийн сургалт, туршлага судлах аялал зохион байгуулж, 150 тариалан эрхлэгчийг хамруулсан. Дүүргийн хэмжээнд 2023 онд тарвасны хүлэмжийн тариалалтыг 0.96 га талбайгаар нэмэгдүүлж, 12 тн ургац хураан аваад байна.	100%
	16	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийг мэргэжил арга зүйн сургалт, туршлага судлах арга хэмжээнд хамруулна.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ	12-14-р хороод	Дүүргийн төсөв	5	нийг сургалтад хам	25-аас доошгүй иргэнийг хамруулж хүлэмжийн тариалалт нэмэгдсэн байна.	1.2		Дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногооны аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн тариалалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран нийт 6 удаагийн сургалт, туршлага судлах аялал зохион байгуулж, 150 тариалан эрхлэгчийг хамруулсан.Үүнд: <ul style="list-style-type: none"> -Дээврийн хүлэмжийн аж ахуйн үрсэлгээ, суулгац бэлтгэх онол, дадлага хосолсон сургалтад 30, -“Хүлэмжийн аж ахуйн зохистой дадал ба Японы хүлэмжийн аж ахуйн тэргүүн туршлага” сургалтанд хүлэмжийн тариалалт эрхэлж буй 20, -“Тариалангийн сэргэлт-2023” чуулганы Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн салбар хуралдаанд 10, -Тариалалт, ургац хураалт, ангилалт, савлалт, хадгалалт, тээвэрлэлтийн үе шатандаа зохистой дадлыг нэвтрүүлэх, бордоо ба хөрсний нэмэлтүүдийн хэрэглээний талаарх мэдлэг олгох сургалтад 30 иргэн, -“Хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь” сургалтад 50 иргэн, - Монгол ногоо төсөлтэй хамтран хүлэмжийн аж ахуй эрхлэгч 10 иргэдэд туршлага судлах аяллыг тус тус зохион байгуулсан. 	100%
	17	Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ		Дүүргийн төсөв	36	20 тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулсан.	20-аас доошгүй тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулна.	9.0	2.9	Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах, газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг 9 байршилд түрээсийн төлбөргүйгээр зохион байгуулж, нийт 115 газар тариалан эрхлэгчдийн 756тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилсан. Мөн төмс, хүнсний ногооны гарал үүсэл, чанар аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьсан.Үүнд: <ul style="list-style-type: none"> - "Монгол ногоо" өргөтгөсөн худалдаа 6 байршилд, 50 газар тариалан эрхлэгч, - "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2023" арга хэмжээнд 10 газар тариалан эрхлэгч, - "Алтан намар" үзэсгэлэн худалдаа 13, 14 дүгээр хороонд, 55 газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулсан. 	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.3.2 Газар тариалан эрхлэгчдэд экологийн цэвэр бордоо ашиглах, экологийн цэвэр тариалан эрхлэхэд нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэн “Хан-Уулд тариалав” брэнд бий болгоно.	18	“Хан-Уулд тариалав” брэнд бий болгоно.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ	12-14-р хороод	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	-	-	1 Брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.	-		Хан-Уулд тариалав брэндийн бий болгох ажлын хүрээнд 13 дугаар хорооны газар тариалан эрхлэгч Ч.Долгорсүрэн нь хүлэмжид айсберг, шанцай, цэцэгт байцаа нутагшуулж, нэр төрлийг нэмэгдүүлж, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас “Хүлэмжийн шинэ соортын хүнсний ногоо тариалж нутагшуулсан ногоочоор” шалгарсан. Мөн “Фор Ви Ар Грийн” ХХК-ийн гүнждийн навч, улаан пооль, “Стандарт барагшун” ХХК-ийн “Барагшун”, “Үлэмж органик” ХХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүн, “Тинц” ХХК-ийн “Ногоодой” жимсний шүүс, “Амаркатеринг” ХХК-ийн 8 төрлийн салатыг брэнд бий болгох зорилгоор нийслэл, дүүргээс зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд оролцуулж, сурталчлах ажлыг зохион байгуулсан.	90%
1.3.3 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилна.	19	Бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ		Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	-	1 арга хэмжээ зохион байгуулж, 20 үйлдвэрлэл эрхлэгчийг оролцуулсан.	30-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг “Хан-Уулд үйлдвэрлэл” сэтгүүлээр сурталчлах ажлыг зохион байгуулна.	-		-Дүүргийн нутаг дэвсгэрт жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 31 иргэн, аж ахуйн нэгжид Дэлхийн конвинеенс сүлжээ дэлгүүрийн бизнесийн шилдэг туршлага, нөү-хау, үйлчилгээний соёл, “СU” хоолны үйлдвэрлэлийн зохистой дадал, ханган нийлүүлэлт, ложистикийн талаарх сайн туршлагыг танилцуулах туршлага судлах аяллыг зохион байгуулсан. -Орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, Африкийн хар загасны ялгадасаар ургамлаа бордож, экологийн цэвэр бүтээгдэхүүн гаргаж авч байгаа бөгөөд Монголд ховордсон гүнждийн навчийг хоол хүнсэнд ашиглах уламжлалыг сэргээсэн “Фор Ви Ар Грийн” ХХК-ийн дээврийн хүлэмжийн аж ахуй, “Гоёл кашмер” ХХК-ийн үйлдвэрийн байртай танилцаж, туршлага судлах 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 65 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан ажилласан. -Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жишиг үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 38 иргэн, аж ахуйн нэгжийг “Хан-Уулд үйлдвэрлэл” сэтгүүлийн 2023 оны ээлжит дугаарт оруулж нийт 1000 ширхэгийг хэвлүүлэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж, олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулсан.	100%
1.3.4 Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	20	Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	2022-2024	ТГУХ, ХХҮХ	ХХҮХ, ЖДҮДТ	Улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусламж	2,500	-	Барилгын ажлын явц 30 хувьд хүрсэн байна.	1,000.0	6.0	Газрын асуудал шийдэгдээгүй.	0%
Шаардагдах төсөв							2,541			1,013.0	6.0		

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.4. Аялал жуулчлал													
1.4.1 Дүүргийн байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн "Их түүхийн жимээр" аяллын маршрутыг бий болгоно.	21	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн явганаар аялах аяллын маршрут бий болгоно	2021-2024	ХүХҮХ, НХХ, ТНААХ	ГЗБА	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	1,000	Богд уул руу алхах 1 маршрут	Тохижилтын ажлын явц 30 хувьд хүрсэн байна.	291.0	392.0 УТХО 14.0 ДТХО	Дүүргийн 8, 21, 23, 24 дүгээр хорооны хил заагт хамаарах Богдхан уулын Хүүш, Арцатын амны 8 км, Нүхт, Ташгайн амны 6.5 км, Жаргалант, Тайны амны 4,5 км, нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, этгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын зураг төсөл боловсруулагдаж батлагдсан бөгөөд 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Нийслэлийн төсвийн 6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, "Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил" хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан бөгөөд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжаар талбайн ашиглалт, арчлалт хамгаалалтыг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулж, цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр гүйцэтгэж, хяналт тавьж ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 0.63 км урт (2990 м.кв) дугуйн зам, 2590 м.кв талбайд явган хүний зам шинээр тавьсан.	100%
1.4.2 Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч хүйтний улиралд иргэд олон нийт чөлөөт цагаа өнгөрүүлэх өвлийн баазыг Яармаг, Сонгино, Жаргалантын аманд байгуулна.	22	Хүйтний улиралд иргэд амарч, зугаалах зориулалт бүхий орчныг бүрдүүлнэ.	2022-2024	ТГУХ, ГЗБА, НХХ		Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	2,000	-	Тохижилтын ажлын явц 50 хувьд хүрсэн байна.	970.0		Нийслэлийн төсвийн 6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Богдхан уулын Дугуй цагааны орчмын тохижилтын ажлын хүрээнд явган хүний болон дугуйн зам, гэрэлтүүлэг, бусад дагалдаж тохижилтын элементүүд бүхий их бүрэн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил хийгдэж дууссан бөгөөд дүүргийн Засаг даргын захирамжаар Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцуулан ажиллаж байна. Дүүргийн 8, 21, 23, 24 дүгээр хорооны хил заагт хамаарах Богдхан уулын Хүүш, Арцатын амны 8 км, Нүхт, Ташгайн амны 6.5 км, Жаргалант, Тайны амны 4,5 км, нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, эдгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын зураг төсөл боловсруулагдаж батлагдсан бөгөөд 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	100%
1.4.3 Богдхан уулын дархан цаазат газрын биологийн олон янз байдлын судалгаанд үндэслэн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	23	Богдхан уулын байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулан, байгалийн аялал жуулчлал хийх орчин бүрдүүлнэ.	2022-2024	ТНААХ, ХүХҮХ	ГЗБА, Хороод	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв	-	-	Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг үндэслэн амралт жуулчны баазуудтай хамтран байгуулна.	-		Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас 9 бүлэг 58 хуудас бүхий "Богдхан уулын дархан цаазат газрын 2022-2026 оны менежментийн төлөвлөгөө"-г боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газраар батлуулсан ба дүүргийн зүгээс төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлж хамтран ажиллалаа. Мөн Дүүргийн 8, 21, 23, 24 дүгээр хорооны хил заагт хамаарах Богдхан уулын Хүүш, Арцатын амны 8 км, Нүхт, Ташгайн амны 6.5 км, Жаргалант, Тайны амны 4,5 км, нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, этгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын зураг төсөл боловсруулагдаж батлагдсан. Нийслэлийн төсвийн 6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, "Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил"-ыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан. Тус ажлын хүрээнд Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 0.63 км урт (2990 м.кв) дугуйн зам, 2590 м.кв талбайд явган хүний зам шинээр тавьсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжаар талбайн ашиглалт, арчлалт хамгаалалтыг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулж, цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр гүйцэтгэж, хяналт тавьж ажиллаж байна.	90%
1.4.4 Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	24	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	2021-2024	ХүХҮХ	ОБХ	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	-	1 удаагийн хамтарсан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	2-оос доошгүй удаа хамтарсан үзлэг шалгалтад ААН-үндийг 100% хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгнө.	-	3.0	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын 32 аж ахуйн нэгжид мэргэжлийн байгууллагуудтай хамтран зочид буудал, дэн буудал, амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага, хотын стандартыг танилцуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр туршлага солилцох, танилцуулах сургалтыг зохион байгуулж 122 ажилтан, албан хаагчдыг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 32 аж ахуйн нэгжид 6 удаагийн хяналт шалгалтыг хийж 19 зөрчилд хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчлийг арилгуулсан. Үүнд: - Ажилчдаа эрүүл мэндийн шинжилгээнд хамруулаагүй, хоолноос дээж авах, бүртгэл хөтлөлт хийдэггүй-8 - Хоол үйлдвэрлэлийн байранд цэвэрлэгээ үйлчилгээ хангалтгүй, агааржуулалтын систем шаардлага хангахгүй-6 - Хог хаягдлыг хугацаанд нь ачуулдаггүй, орчны бохирдол ихтэй-5 Мөн согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу ажилчдыг хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамруулах, хаягийн байгууламжийг стандартын дагуу сайжруулах чиглэлээр зөвлөмж өгсөн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.4.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	25	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, ой хээрийн түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021-2025	ОБХ			-	2 удаагийн сургалт зохион байгуулсан.	2 удаагийн дадлага сургалт зохион байгуулна.	-		Урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Цагдаагийн газартай хамтран Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо Богд Хан уул Зайсангийн аманд Хүн бүр байгаль хамгаалагч уриан доор зохион байгуулж, түймрээс сэргийлэх 2 төрлийн 8 ширхэг самбарыг иргэд олноор алхдаг газруудад байршуулан 3 төрлийн сэрэмжлүүлэг материал тараасан. "Ногоон бүсийг ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах дадлага сургууль"-ийг дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/299 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Ой хээрийн түймрийн штабын дадлага сургуулийн батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо Морингийн давааны зүүн энгэрт зохион байгуулсан. Дадлага сургуульд дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангиудад дадлага хийж байгаа Хууль сахиулах их сургуулийн Ахлагчийн сургуулийн 15 сонсогч, нийт 132 хүн, 12 техник хэрэгсэлтэй ажиллаж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын дунд гал түймэр унтраах сорил дадлагын уралдаан, тэмцээн зарлан нийт 8 багийн 24 тамирчид хүч авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдөн 1 дүгээр байранд "Мишээл групп" ХХК шалгарч, Засаг даргын өргөмжлөлөөр шагнагдсан.	100%
Шардагдах төсөв							3,000			1,261.0	409.0		
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ							15,012			4,438.9	5,762.4		93%
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ													
2.1. Биеийн тамир, спорт													
2.1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	26	Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр зохион байгуулна.	2021-2024	НХХ, БТСХ	НХХ	Дүүргийн төсөв	209	Иргэдийн наадамд 3500 иргэн хамрагдсан.	Иргэдийн наадамд 3800 иргэн хамруулсан байна.	90.7	87.3	Дүүргийн Иргэдийн спортын XI их наадмыг 2023 оны 05 сараас 11 сарын хооронд 3 үе шаттайгаар явган аялал, орс талалт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аеробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр зохион байгуулж 25 хорооны нийт 4900 иргэн хамруулсан. Иргэдийн спортын XI их наадмын нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд шалгарсан 150 баг тамирчид оролцож, алтан медаль-4 ширээний шагай /эм/, хийн дасгал, сагс бөмбөг /эр/, дартс, мөнгөн медаль-1 явган аялал, хүрэл медаль-3 орс талалт /эр, эм, сагсан бөмбөг /эм/ нийт 7 медаль 38 оноогоор 1-р байр эзэлж байна.	100%
	27	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Улаанбаатар Марафон, автомашингүй өдөр, спортлог Улаанбаатар өдөрлөг, гүйлт гэх мэт/	2021-2024	НХХ, БТСХ	НХХ	Улс, Дүүргийн төсөв	75	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 4727 хүн оролцсон.	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 5400-аас доошгүй хүн хамруулна.	20.0	215.8	Хан-Уул дүүрэгт 2023 онд нийтийн биеийн тамирын чиглэлээр "Хамтдаа хэвшүүлбэ" 21 хоногийн аянд 7879 иргэн, хороод болон ӨЭМТ-ийн ажилтан албан хаагчдын дундах спортын 3 төрөлт тэмцээнд 253, СӨБ багш нарын тэмцээнд 620 багш, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 2 арга хэмжээнд 72 иргэн, "Цаг гаргая" аянд 2531 иргэн, "Эрүүл мэндийн цахим гүйлт"-ийн тэмцээнд 209 иргэн, дүүргийн аж ахуй нэгжүүдийн 3 төрөлт тэмцээнд 248 иргэн, цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнд 600 хүүхэд, дүүргийн залуучуудын сагсан бөмбөгийн Нисэх, яармаг, алсын бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 160 иргэн, "Улаанбаатар марафон 2023" 6586 иргэн, Бүтээгч Хан-Уул өдөрлөгт 4820 иргэн, Хамтдаа алхаад эрүүлжбэ аянд 172 иргэн, Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 6 төрөлт тэмцээнд 72 иргэн, Хан-Уул дүүргийн иргэдийн спортын XI их наадамд спортын 9 төрлөөр хороо, дүүрэг гэсэн 2 үе шаттайгаар 25 хорооны 4900 иргэн автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээнд 300 иргэн, ХУД-н иргэдийн спортын XI наадамд 4900 иргэн, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит "Хүмүүнлэгийн од" волейболын тэмцээнд 224 иргэн, Биеийн тамир спортын хорооноос зохион байгуулсан 8 төрлийн сургалтад 62 байгууллагын 156 иргэн гэх мэт нийт 73 томоохон арга хэмжээнд 1016 байгууллагын 64,527 иргэдийг хамруулан улсын төсвөөс 47,409,800 төгрөгийг, орон нутгийн төсвөөс 168,446,000 төг, бусад төсвөөс 15,900,000 төгрөгийг зарцуулан ажиллалаа.	100%
	28	Өвлийн спортын үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021-2024	НХХ, БТСХ	НХХ	Улс, Дүүргийн төсөв	21	Өвлийн улиралд зохион байгуулагдсан арга хэмжээнд 3500 хүн хамрагдсан.	Оролцогчдын тоог 4000-аас доошгүй хүн хамруулна.	5.5	14.0	"Мөнгөн Хан-Уул" өвлийн биеийн тамир спортын арга хэмжээг иргэд аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын дунд 4 удаа зохион байгуулж, 79 байгууллагын нийт 1153 иргэн, албан хаагч хамрагдсан. Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмын 4 төрөлд 53 тамирчин, Монголын Бүх ард түмний өвлийн спортын XVI наадмын шигшээ тэмцээний 3 төрөлд 9 тамирчин оролцсон. Хан-Уул дүүргийн хэмжээнд цанын бааз-1, мөсөн гулгуурын задгай талбай -1, битүү 2 талбайд 27720 иргэн, хүүхэд, залуусыг хичээллүүлсэн. Өвлийн спортын арга хэмжээнд нийт 28.935 иргэн хамрагдсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.1.2 Дүүргийн төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	29	Дүүргийн Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг ААН-үүдийн дунд жил бүр зохион байгуулна.	2021-2024	НХХ, БТСХ	БТСХ	Дүүргийн төсөв	90	Тэмцээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудын 860 албан хаагчид хамрагдсан.	Спортын арга хэмжээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудын 900-аас доошгүй албан хаагчийг хамруулна.	25.0	20.0	Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж 35 аж ахуйн нэгжийн 300 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. Засаг даргын санаачилгаар дүүргийн ахмад иргэдийн дунд зохион байгуулсан шатрын тэмцээнд 25 байгууллагын 64 иргэн, Залуучуудын сэгсэн бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний шигшээ тоглолтонд 12 багийн 120 тамирчин, нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд уламжлал болон зохион байгуулагддаг Засаг даргын нэрэмжит спортын таван төрөлт тэмцээн 2023 оны 06 сарын 13-18 ны өдрүүдэд спортын 5 төрлөөр / дартс, шатар, сагсан бөмбөг, корнхол/ зохион байгуулагдаж 24 байгууллагын 680 ажилтан, албан хаагчид хамрагдсан. Дээрх уралдаан тэмцээнд нийт 1164 ажилтан, албан хаагч, иргэд хамрагдсан.	100%
2.1.3 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор фитнес болон спорт клубуудыг бодлогоор дэмжиж, иргэдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн спорт клуб байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	30	Фитнес болон спорт клубуудтай хамтран иргэдийн эрэлт хэрэгцээ сонирхолд нийцсэн спорт клуб байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	2021-2024	НХХ, БТСХ	Хороод	Дүүргийн төсөв	-	3 клубтай хамтран ажилласан.	1-2 төрлийн сайн дурын клуб байгуулсан байна.	-	-	Дүүргийн хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 77 спорт клубээс магадлан итгэмжлэгдсэн клуб 1 ажиллаж байна. Дүүргийн 8 дугаар хороонд шинээр волейболын клуб, бужигийн клуб, гийр, кардио дасгалын клуб, дүүргийн 11 хороонд шинээр буудлагын SNIPER клуб, 1 дүгээр хороонд Таеквондогийн "Эхлэл" клуб тус тус байгуулагдан дүүргийн Биеийн тамир, спортын хороотой хамтран ажиллаж байна. Холбогдох хуулинд өөрчлөлт орж байгаа тул "Магадлан итгэмжлэл" хойшилсон.	100%
2.1.4 Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна.	31	Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.	2021-2024	НХХ, БТСХ, ГБХЭХХ	Хороод	Дүүргийн төсөв	250	Спортын 10 төрлөөр шигшээ баг байгуулж спортын үйл ажиллагааг нь дэмжсэн.	Спортын 14-өөс доошгүй төрлийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжсэн байна.	77.9	162.9	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг нь хоккей, бокс спортын 2 төрлийн багш сонгон шалгаруулж авснаар нийт 11 төрлөөр 310 тамирчин бэлтгэж байна. Шинээр Бочи спортын төрлөөр нийслэлийн 63 дугаар сургуультай хамтран хөгжлийн бэрхшээлтэй өсвөрийн тамирчдыг хичээллүүлж шигшээ багийн тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 2023 оны III улирлын байдлаар улсын төсвөөс 42,666.000 төгрөг, захирамжаар 53,418,000 бусад төсвөөр 66,830,000, нийт 162,914 сая төгрөгийг зарцуулсан. Дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчид улсын хэмжээнд спортын 11 төрлөөр 37 удаагийн тэмцээнд 687 тамирчин оролцож алтан медаль 69, мөнгөн медаль 54 хүрэл медаль 93 нийт 216 багц медаль хүртээд байна.	90%
2.1.4 Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна.	32	Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг Олон улсын уралдаан тэмцээнд бэлтгэж оролцуулна.	2021-2024	НХХ, БТСХ	НХХ	Дүүргийн төсөв	50	-	Дүүргийн өсвөрийн шигшээ баг тамирчдыг Зүүн Азийн залуучуудын анхдугаар наадамд бэлтгэн оролцуулах.	30.0	71.5 Зөв хүүхэд-Зөв ирээдүй хөтөлбөр	Олон улсын шинж чанартай 9 тэмцээнд 34 тамирчин оролцуулж, 5 алт, 3 мөнгө 12 хүрэл, нийт 20 медаль хүртсэн амжилт гаргасан. Үүнд: 1. Казахстаны Алматы хотноо зохион байгуулагдсан Өсвөр үеийн Азийн цомын тэмцээнд 4 тамирчин оролцож алтан медаль 1, хүрэл медаль 1, 2. ОХУ-ын Красноярска хотноо зохион байгуулагдсан "Красноярская лига" жудо бөхийн олон улсы тэмцээнд 11 тамирчин оролцож, алтан медаль 4, мөнгөн медаль 1, хүрэл медаль 4, 3.Зүүн азийн хүүхдийн наадмын боксын тэмцээнд 4 тамирчин оролцож хүрэл медаль 3, 4. Казахстаны нийслэл Астана хотноо зохион байгуулагдсан Самбо бөхийн Азийн аварга шалгаруул тэмцээнд 3 тамирчин оролцож мөнгөн медаль 2, хүрэл медаль 1, 5. Хорват улсын Загреб хотноо зохион байгуулагдсан Жудо бөхийн дэлхийн аварга шалгаруул тэмцээнд 2 тамирчин ороцож 5-р байрт 1, 6. ОХУ-ын Екстабург хотноо зохион байгуулагдсан олон улсын тэмцээнд 4 тамирчин оролцож хүр медаль 3 7. ХБНГУ-д зохион байгуулсан Тусгай олимпын дэлхийн зуны наадамд оролцож 3 тамирчин, 8. Египет улсад Өсвөрийн шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож 2 тамирчин, 9. Тайланд улсад зохион байгуулагдсан Азийн өсвөр үеийн сэврээт сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээнд 1 тамирчин тус тус оролцсон.	100%
2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	33	Дүүргийн спорт цогцолборын барилга шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүргийн төсөв	10,200		Барилгын ажлын явц 50 хявд хүрсэн байна.	6,000.0		Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд "Спорт цогцолборын барилга"-ын зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр "Классик хаус" ХХК-тай гэрээ байгуулсан. Спорт цогцолборын барилга нь 586 үзэгчийн суудалтай, сагсан бөмбөг, бокс, ширээний теннис, ханын теннис, байт харваа, усанд сэлэлт, шатар даам, бөхийн танхимууд, фитнес, ресторан, хурлын заал, болон бусад дагалдах өрөө тасалгаатайгаар төлөвлөгдөж, загвар зураг батлагдсан. Ажлын зураг төсөв боловсруулах шатанд газрын маргааны улмаас түр зогсоод байна.	30%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	34	Нийтийн эзэмшлийн талбай болон Ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд спорт талбай байгуулна	2021-2024	ТГУХ, ТНААХ	Хороод, ЕБС-ууд	Улс, нийслэл, дүүргийн төсөв	952	Нийт 8 спорт талбай байна.	2 байршилд спорт талбай байгуулсан байна.	1,925.0	1,117.2 ДТХО	Нийтийн эзэмшил болон сургууль, цэцэрлэгийн гадна талбайн нийт 15 байршилд спорт талбай байгуулах ажлыг хэрэгжүүлснээс Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 13, 21 дүгээр хорооны 4 байршилд он дамжин хэрэгжсэн 3х3 сагсан бөмбөгийн талбайн ажил бүрэн хэрэгжи дууссан бол шинээр 8, 12, 24 дүгээр хороодод хийгдэж буй 3х3 сагсан бөмбөгийн 3 талбайг 12 дугаар сард ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 4 дүгээр хороо, 34 дүгээр сургуулийн гадна талбай, 25 дугаар хороо, Буянт-Ухаа 1 хорооллын 2 байршилд 3х3 сагсан бөмбөгийн нийт 3 талбай байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Нано бриллиант констракшн" ХХК шалгарч, талбайн цутгалтын ажлыг гүйцэтгэсэн тус ажил 2024 оны 4-р сард ашиглалтад орно. -Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй тохижилтын ажлын хүрээнд 10-р хорооны 60/2 байрны гадна талбай 14-р хороо 59 дүгээр сургуулийн гадна талбайд 3х3 талбай, 29, 73, 144 дүгээр цэцэрлэгийн гадна талбайд мини сагсан бөмбөг, хөл бөмбөгийн талбай туусту хийгдсэн.	100%
Шардагдах төсөв							11,847			8,174.1	1,617.2		
2.2. Эрүүл мэнд													
2.2.1 Иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, зорилгоор "Цахим эмч" онлайн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.	35	Иргэд өөрсдөө чихрийн шижин, цусны даралт зэрэг зонхилон тохиолдох өвчнийг өдөр тутам хянах, онлайн зөвлөгөө, үйлчилгээ авах цахим системийг нэвтрүүлнэ.	2022-2023	НХХ, ЗМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Нийслэл, дүүргийн төсөв	60	-	"Цахим эмч" систем ашиглаж эхэлсэн байна.	60.0		Нэгдсэн эмнэлгийн салбар Амбулаторийн 2 давхарт 9 өрөөтэй "Телемедицин төв" байгуулагдаж, насанд хүрэгчдийн зайн үзлэг оношилгоо хийх иж бүрэн 7, бусад 3 суурин компьютеруудын, сүлжээ, тоног төхөөрөмж ашиглагдахад бэлэн болсон. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр facebook, page хуудсанд байршуулсан шторк мэдээлэл, зөвлөгөөний хандалт-10000, TV-5 телевизийн эмч зөвлөж байна 2 удаа ярилцлага 15000 иргэнд хүрсэн.	70%
2.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.	36	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна.	2021-2024	НХХ, ЗМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Улс, нийслэл, дүүргийн төсөв	60	Артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 80 хувь, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 37 хувь, Хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 78 хувь хамрагдсан.	Артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 80 хувь, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 37.4 хувь, хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтыг 75 хувьд хүргэж эрт үед нь эмчилсэн байна.	15.0		Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоонд Хан-Уул дүүргийн хэмжээнд хамрагдвал зохих 18-аас дээш насны нийт 143574 хүнХалдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоонд Хан-Уул дүүргийн хэмжээнд хамрагдвал зохих 18-аас дээш насны нийт 143574 хүн эрэгтэй 64631, эмэгтэй 78943 байна. Үүнээс; -Артерийн даралт ихсэх өвний эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд 104971 буюу 72 % нь хамрагдсан. Үүнээс Эрэгтэй 40791 буюу 38.8%, Эмэгтэй 64180 буюу 61.2 %, эдгээр үзлэгээс давтан үзлэгт нийт 24699 иргэн хамрагдсанаас шинээр артерийн даралт ихсэн өвчин 199 оношлогдсон байна. -"Чихрийн шижин, хэв шинж-2" эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 35-аас дээш насны 89860 хүн амын эрэгтэй 40021, эмэгтэй 49839, үүнээс үзлэг оношилгоонд 83605 иргэн буюу 93% нь хамрагдсанаас эрэгтэй 32531 буюу 38.9%, эмэгтэй 51074 буюу 61.1% нь хамрагдаж, давтан үзлэгт 10303 иргэн орсноос шинээр чихрийн шижинтэй 26 иргэн оношлогдож хяналтанд орлоо. -Умайн хүзүүний /3 жилийн давтамжтай / эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамрагдвал зохих 30-аас 60, түүнээс дээш насны 14301 зорилтот эмэгтэйчүүдээс 7100 эмэгтэй буюу 50% нь хамрагдсан. -Хөхний үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 20-оос дээш насны зорилтот 58138 эмэгтэйдгээс 49644 буюу 85%-ийн хамрагдалттай байна.	100%
2.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.	37	БЗДХ/ДОХ, сүрьеэ халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулна.	2021-2024	НХХ, ЗМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Улс, нийслэл, дүүргийн төсөв	-	ХДХ/ДОХ/БЗДХ-ын идэвхтэй эрт илрүүлэг 5960, гепатитын тохиолдлын түвшин-0.8.	Халдварт өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт 6000 иргэнийг хамруулж, эрт үед нь эмчилсэн байна.	-		2023 оны статистик тоо мэдээгээр сүрьеэ, халдварт, БЗДХ/ДОХ-ын кабинетээр диспансерийн хяналт-2223, урьдчилан сэргийлэх үзлэг -19032, амбулаторын үзлэг-8115, дуудлага-3, нийт 29373 иргэнд үзлэг хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Үүнээс: Идэвхтэй эрт илрүүлэгт хамрагдсан 15335 иргэнээс 157 шинэ тохиолдол илэрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бэлгийн замаар дамжих халдварт өвчлөл 58 тохиолдлоор буюу 2.1 промилоор өссөн үзүүлэлттэй байна. Шинэ илэрсэн тохиолдлоос Тэмбүү -103 /жирэмсэн 27/, Заг хүйтэн-41, Трихомониаз-13 халдвар илэрснийг 100% эмчилсэн. 2023 оны 2-3 сард Өрхийн Эрүүл мэндийн 15 төвийн 142 эмч, сувилагчдад БЗДХ-ийн кабинетаас мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт үнэлгээ хийсэн. "Эрэг хандлага-Эрүүл оюутан" оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Харьяа их дээд сургууль, МСУТ, коллежийн 253оюутан сурагчдад Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулж, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Үүнээс тэмбүүгийн 2 шинэ тохиолдол батлагдаж эрүүлжүүлсэн. ХУД-ийн 14-р хороонд орших Өлзийт асар ТББ-ын байранд орон гэргүй 76 иргэдийн дунд эрүүл мэндийн идэвхитэй эрт илрүүлэгт хамруулахад тэмбүүгийн 23 эерэг тохиолдол гарсан. Үүнээс шинэ 2 тохиолдол батлагдаж эрүүлжүүлсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.	38	Сүрьеэгийн эрт илрүүлийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор сүрьеэгийн төвийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоог нэмэгдүүлнэ.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Дүүргийн төсөв	-	Сүрьеэгийн шинэ тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.9 байна.	Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, шинэ тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.6-д хүргэнэ.	-	2023 онд 11814 иргэнд үзлэг хийж, амбулаторийн үзлэг 3566, Диспансерийн үзлэг 1633, Урьдчилан сэргийлэх үзлэг 6612, дуудлага-3 байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн 4826 нь рентген шинжилгээнд, 927 нь түрхэцийн шинжилгээнд хамрагдсанаас шинэ түрхэц эерэг гарсан 91, G-Xpert-ийн шинжилгээнд орсон 674, туберкулины сорил тавьсан 185 иргэнээс хэт өндөр урвалтай 51 хүн байна. Дээрх үзлэг шинжилгээнээс шинэ сүрьеэтэй-124, дахилт-14, шилжиж ирсэн-4, бусад-8, эмэнд тэсвэртэй сүрьеэ-13, нийт 168 тохиолдлыг эмчилгээнд хамруулан эмчилгээг 6-8 сар хяналтад байна. Сүрьеэгийн 124 шинэ тохиолдол илрүүлж эмчилсэн нь 10000 хүн амд 5.5 промил байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 4 тохиолдол буюу 0,8 промилээр буурсан. Хяналтанд орж эмчлэгдэж байгаа 168 өвчтөний хавьтал 328 иргэнийг шинжилгээнд хамруулж 68 хавьтлыг далд халдварын эмчилсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 дахин өссөн, индекс тохиолдлын хавьтлын үзлэгт хамрагдалт 90%-д хүрсэн. Солонгосын үндэсний сүрьеэгийн Нийгэмлэгтэй хамтран рентген аппараттай автобустай баг, гэрээр явуулын баг хэвтрийн иргэд болон өмнө бүртгэгдсэн сүрьеэгийн өрхийн хавьтлын илрүүлэг үзлэгийг 26 удаа зохион байгуулж 651 иргэн хамруулснаас сэжигтэй 54 тохиолдлыг цэрний шинжилгээнд хамруулж, нян судлалаар батлагдсан 4, эмнэлзүйгээр 3 тохиолдлыг эмчилсэн. Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн 2097 иргэнийг үзлэгт хамруулан сүрьеэтэй байж болзошгүй 46 иргэнийг цэрний түрхэцийн болон жене эксперт шинжилгээнд хамруулж, нян судлалаар батлагдсан 7, эмнэлзүйгээр 2 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан.	100%	
	39	Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Улс, нийслэл, дүүргийн төсөв	-	Тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тололт дархлаажуулалтын хамралт 96.7 хувь.	Товлолт дархлаажуулалтын хамралтыг 98.2 хувьд хүргэсэн байна. ковид-19 халдварын эсрэг вакцины хамрагдалтыг нэмэгдүүлэх.	-	2023 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний тололт дархлаажуулалтын хамралт вакцин тус бүрээр: Халдварт саагийн вакцины бүрэн тунд 4580 хүүхдээс 4569 /99.7%/, тавт вакцины бүрэн тунд 4575 хүүхдээс 4564 /99.7%/, /Давхардсан тоогоор саагийн вакцины 1-4 дүгээр тунд нийт 18349 хүүхдээс 18304 /99.7%/, тавт вакцины 1-3 дугаар тунд нийт 13886 хүүхдээс 13854 /99.7%/, хүүхэд хамрагдсан./, улаанбурхан, гахай хавдар, улаанууд /УГУ/-ын эсрэг вакцины бүрэн тунд 4040 хүүхдээс 4001 /99.0%/, А-гепатитын вакцины бүрэн тунд 4017 хүүхдээс 3978 /99.0%/, Пневмококкийн эсрэг вакцины бүрэн тунд 4114 хүүхдээс 4091 /99.4%/, Сахуу татрангийн вакцины бүрэн тунд 3520 хүүхдээс 3510 /99.7%/хүүхэд тус тус хамрагдсан. "Ковид-19" халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 1-р тунд 15, 2-р тунд 24, 3-р тунд 87, 4-р тунд 27, 5-р тунд 4 иргэн, нийт-157 иргэнийг хамруулсан.	100%	
2.2.3 Дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	40	Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	2022-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ		Нийслэлийн төсөв	40	Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинетгүй байна.	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	20.0	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт Эрчүүдийн кабинетийг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэдээлэл 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулж, төгссөн бөгөөд 943 иргэнд үзлэг оношлогоо хийж, мэдээлэл хийлгэх шаардлагатай нийт 103 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн. Мөн цэргийн насны залуучуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийж 46 үйлчлүүлэгч өвчтэй буюу мэдээлэл эмчилгээ хийлгэх шаардлагатай болохыг илрүүлсэн бөгөөд эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийн яармаг амбулаторт эрэгтэйчүүдийн кабинетыг шинээр байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	100%	
2.2.4 Эх хүүхдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сайжруулна.	41	Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Улс, нийслэл, дүүргийн төсөв	40	Жирэмсэн эмэгтэйчүүд 89.5 хувь нь жирэмсний эхний 3 сард хяналтад хамрагдсан.	Жирэмсний эхний 3 сарын хяналтыг 90,7 хувьд хүргэнэ.	10.0	Хан-Уул дүүрэгт 2023 онд байдлаар шинээр жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийн 4598 үүнээс 0-3 сартай хяналтад орсон 4189 буюу жирэмсний эрт хяналт 91.1 хувьтай байна. Одоогийн байдлаар Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт нийт 2227 жирэмсэн эмэгтэйчүүд хянагдаж байна.	100%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	42	Хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Улс, нийслэлийн төсөв	40	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.2 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1.0 байна.	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.4 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 0.98 байна.	10.0		2023 оны эхний 10 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдлийн 35 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 7.2 промилль, УБ хотын дундаж -12.0 промилль байна. 1-5 насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн нь 0.7 промилль, УБ хотын дундаж 1.2 промилль байна. Өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт эхний 10 сарын байдлаар 3938 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс 0-1 насны 918, 1-4 насны 2035, 5-9 насны 518, 10-14 насны 228, 15-19 насны 239 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн байна. Амьсгалын тогтолцооны өвчнөөр 1747, хоол боловсруулах үдмын өвчлөлөөр 310 хүүхэд эмчлүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2023 оны А/380 дугаар захирамжаар "Эх , хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" орон тооны бус салбар зөвлөл байгуулж, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн шалтгааныг магадлан хэлэлцэх хурлыг 3 удаа зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хүүхдийн зүрх судасны төрөлжсөн мэргэшлээр 1, уушги төрөлжсөн мэргэшлийн эмчээр 1 , хүүхдийн нарийн мэргэшлийн сувиллагчаар 1 сувиллагч тус тус ЭХЭМҮТэвтэй гэрээний дагуу суралцуулж байна. Хүүхдийн өвчний менежментийн шинэчилсэн модуль 5 өдрийн цогц сургалтад Хүүхдийн болон өрхийн 18 эмч, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 32 эмчийг тус тус хамруулсан"Эх ,хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" өдөрлөгөөр хүүхдийн эмчийн үзлэгт 23 хүүхдийг хамруулан, 46 хүүхдийн асран хамгаалагчдад бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө, 51 эхэд нярайн асаргаа сувилгааны талаарх зөвлөмжийг тус тус өгсөн.	100%
2.2.5. "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх, бууруулах арга хэмжээг зохион байгуулна.	43	СӨБ болон ЕБС-ийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох сургалт, үзлэг зохион байгуулна.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ	БХ	Дүүргийн төсөв	12	Үзлэгт 18628 хүүхэд, 189 багшийг сургалтад хамруулсан.	2000 хүүхэд, 2 үзлэг, 2 сургалт.	3.0		Хан-Уул дүүргийн хэмжээнд 2023 онд 30128 хүүхэд амны хөндийн үзлэг хийж, сургалт зохион байгуулсан. Үүнд: Дүүргийн Нэгдсэн эмнэлэг ерөнхий боловсролын 29, 34-р сургуулийн 96 сурагчийг хамруулан "Амны хөндийн эрүүл ахуй" сэдэвт сургалт, Хүүхдийн кабинетаар үйлчлүүлж буй 100 орчим хүүхэд, эцэг эхчүүдэд "Амны хөндийн эрүүл мэнд, шүд зөв угаах арга барил" сургалт тус тус зохион байгуулан 547 гаруй хүүхэд амны хөндийн үзлэг хийж, эмчилсэн. Эрүүл мэндийн төвийн амбулаторийн шүдний үзлэгт 11265 хүүхэд, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 18316 хүүхэд хамрагдаж нийт 29581 хүүхэд амны хөндийн үзлэг зөвлөгөө авсан байна. "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд үзлэгт орсон хүүхдийн 58,9 % буюу 17748 хүүхэд амны хөндийн өвчлөлтэй байсан бөгөөд шүд цоорлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1785 хүүхэд фторт түрхлэгийг түрхэж багш, эцэг эх, асран хамгаалагч нарт амны хөндийн эрүүл мэнд, шүдээ хэрхэн угаах заавар, зөвлөмж өгсөн.	100%
2.2.6. Үйлчилгээний жишигт нийцсэн Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг тодорхой бүсүүдэд барьж байгуулна.	44	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	2021-2023	ТГУХ, ГЗБА		Улс, нийслэл, дүүргийн төсөв,	8,200	5 өрхийн эрүүл мэндийн төв түрээсийн байранд үйл ажиллагааг явуулж байна.	1-2 ӨЭМТ-ийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна.	1,800.0	104.2	Хан-Уул дүүрэгт 2023 онд нийт 5 хороонд өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажил хэрэгжиж байна. Үүнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: -14 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилга ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн. -8 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дотор заслын ажил хийгдэж байна. Барилгын ажлын явц 90 хувь. -16 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дотор заслын ажил хийгдэж байна. Барилгын ажлын явц 90 хувь. Дүүргийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар: -21 дүгээр хороонд хэрэгжүүлсэн хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын ажил дуусаж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн. -15 дугаар хорооны хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын дотор засал болон гадна фасад хийгдэж, барилгын ажлын явц 80 хувьтай үргэлжилж байна.	100%
2.2.7. Жишиг нэгдсэн эмнэлгийн загвараар дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулна.	45	Жишиг загвараар нэгдсэн эмнэлэг байгуулах ажлыг хамтран зохион байгуулна.	2022-2024	ТГУХ, ХУДНЭ		АХБ-ны зээл тусламж	6,000	-	Барилгын ажлын гүйцэтгэлээр 70 хувьд хүрсэн байна.	2,500.0	162.9 ДТХО	Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд Азийн хөгжлийн банк"-ны санхүүжилтээр хэрэгжих 200 ортой жишиг нэгдсэн эмнэлэг барих барилгажилтын талбайд өртсөн нэгдсэн эмнэлгийн хуучин 5 объект буулгалтын ажлыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа бөгөөд гүйцэтгэгчээр "Юу зэт эрдэнэ" ХХК шалгарч, 7 барилга буулгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. "Азийн хөгжлийн банк"-ны буцалтгүй тусламжаар олон улсын жишиг загвараар барих Нэгдсэн эмнэлэгийн барилгын зураг төсөв батлагдсан, олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч шалгаруулах шатанд байна. Эмнэлгийн 2024 онд хэрэгжиж эхлэнэ.	30%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.2.8. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, эмч, сувилагчдын үр чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх зорилгоор “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	46	“Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ	ӨЭМТ-үүд	Дүүргийн төсөв	75	-	Хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	70.0	94.1 Эрүүл дүүрэг дэд хөтөлбөр	“Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн 1, 3, 4 дүгээр зорилтын хүрээнд нийт 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн Үүнд: 1. Тусгай олимпын дэлхийн зуны наадамд оролцох 3 тамирчинд 4.5 сая төгрөгийн дэмжлэг; 2. 14 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай хяналтын монитор, дерберлятор, хүчилтөрчийн баллон, тарианы сандал, кварцийн гэрэл зэрэг тоног төхөөрөмж; 3.Хан-Уул дүүргийн 14 хорооны Засаг даргын ажлын алба болон “Энх амгалан Өлзийт” ӨЭМТ хамтран “Шүд эрүүл бол бие эрүүл” төсөл хэрэгжүүлэн 165, 300 дугаар цэцэрлэгийн 543 хүүхдийг амны хөндийн үзлэг оношилгоо хийж, фторт түрхлэг түрхэж эрүүлжүүлсэн. 4. Нийслэлийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 150 гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд “Эко дүүрэг-Эрчимтэй хөдөлгөөн” спортын 5 төрөлт тэмцээн зохион байгуулсан. 5.Дүүргийн 25 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд шаардагдах хэрэгслийг нийлүүлсэн. 6. Нисэх, алсын бүсийн хороодын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын 163 дугаар сургууль дээр техник тоног төхөөрөмж бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн өрөө”-г нээж тохижуулсан. 7. Дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс “Зорилтот өрхийн иргэдэд эрүүл мэндийн багц” олгох төсөл тус тус хэрэгжүүлсэн.	70%
	47	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, ажилтнуудын мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	НХХ, ЭМТ, ХУДНЭ		Улс, нийслэл, дүүргийн төсөв,	80	Гадаад сургалтад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо 13 байна.	Үндсэн мэргэшлийн сургалтад 15-25 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан байна.	20.0		Дүүргийн хэмжээнд төрөлжсөн болон нарийн мэргэжлээр 21, гадаад сургалтад 9, богино хугацааны чадавжуулах сургалтад давхардсан тоогоор 249 эмч сувилагчид хамрагдсан. Үүнд: Эрүүл мэндийн төвөөс 2023-2024 онд дотор судлал, БЗДХХДХВДОХ, андрологи, статистик, зүрх судас, био анагаах, нян судлал, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, эмэгтэйчүүдийн эхо оношлогоо, ургийн эхо оношлогоо, хавдрын хими эмчилгээ, тархины судасны бичлэг, туслах сувилагч зэрэг чиглэлээр нарийн мэргэжлийн, төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх, мэргэжил олгох, урт хугацааны сургалтад 17 эмч, гадаадын сургалтад 7 эмч, богино хугацааны чадавжуулах сургалтад давхардсан тоогоор 186 эмч тус тус хамрагдсан байна. Нэгдсэн эмнэлэг хүүхдийн эмчээр Хүүхдийн зүрхний эмч-1, Хүүхдийн уушигны эмч-1, Гэмтлийн үе мөч солих мэс заслын, чих хамар хоолойн нарийн мэргэжлийн эмч-2, дурангийн мэс заслын богино хугацааны мэргэшүүлэх сургалтад -2 эмч, 1 сувилагч, гадаадын сургалтад 2, богино хугацааны чадавжуулах сургалтад давхардсан тоогоор 60 эмч хамрагдсан.	100%
2.2.8. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, эмч, сувилагчдын үр чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх зорилгоор “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	48	Дүүргийн эрүүл мэндийн төсөвт байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.	2021-2024	ТГУХ, НХХ, ЭМТ, ХУДНЭ		Улс, нийслэл, дүүргийн төсөв	1,095	2021 оны төсөвт тоног, төхөөрөмжөөр хангахаар төсөв тусгагдсан.	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	200.0	456.0 НЭМГ 260.2	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр яаралтай тусламж, гэрийн эргэлт, эмчилгээнд зориулж, 3, 4, 7 дугаар хорооны 3 ӨЭМТ-д үйлчилгээний автомашин хүлээлгэн өгсөн. Мөн 3, 4, 5, 6, 7, 8, 11 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 7 хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 51 нэр төрлийн нийт 119 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үйлчилгээний 2 автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгч шалагрсан, нийлүүлэгдэх шатанд, нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн иж бүрэн засварыг хийж, ашиглалтад оруулсан бол хэвлийн иж бүрэн дурангийн төхөөрөмж, ариутгах аппаратын хамт нийлүүлэх, ууд худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдийн тасаг болон телемедицины үйлчилгээ үзүүлэх төвийн иж бүрэн иж засвар шинэчлэлтийн ажлууд хийгдсэн. Яармаг харьяа амбулаторийн эмнэлэгт хүлээн авах танхим, өлгүүрийн өрөө, тусламж үйлчилгээний клиникийн танхим болон чихрийн шижингийн цогц төвийг байгуулан ашиглалтад оруулж, чихрийн шижингийн үзлэг, оношилгоо, зөвөлгөө өгч байна.	100%
	49	Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийг дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн байгуулах ажлыг зохион байгуулна	2021-2023	НХХ, ЭМТ, ХУДНЭ		Улс, нийслэлийн төсөв	1,050	Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо-0.	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна.	800.0	601.0	Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/38 дугаар тушаалаар аймаг, дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг батлуулахаар Нийслэлийн Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн яаманд санал хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэд Эрүүл мэндийг дэмжих төв 2022 оноос үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс тус төвд "иргэн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ,оношилгоог зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 209,524 иргэн хамрагдахаас 116,078 иргэн буюу 55.4 хувийн хамрагдалттай, нийслэлийн хэмжээнд 2-рт байна.	70%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.2.9 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор "Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулна.	50	"Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангана.	2021-2024	НХХ, ТНААХ	ЭМТ, ХУДНЭ, Хороод	Дүүргийн төсөв	18	2 удаагийн сургалт өдөрлөг зохион байгуулж, 3878 иргэнийг хамруулсан.	Сургалтыг зохион байгуулж, 4000-аас доошгүй иргэнийг хамруулна.	5.0		"Хоггүй Хан-Уул 2023" аяны хүрээнд Харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл хүргэх 2 төрлийн постерыг Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар байршуулан иргэдэд мэдээллийг хүргэсэн. Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургууль, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн хамтарсан тус бүр 10 эмчийн бүрэдхүүнтэй 2 баг төвийн бүст "Мөнхбадрах" ӨЭМТ, яармаг бүст "Хашчагнуур" ӨЭМТ, нисэх бүст "Энхбуянтманал" ӨЭМТ-үд ажиллан иргэдэд харшлын өвчний талаарх ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, харшлын сорилд 1500 гаруй иргэнийг хамруулсан.	50%
	51	Харшлын өвчин үүсгэгч шарилж, газрын хөл ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	2021-2024	ТНААХ	Хороод, НЗБ-ууд	Дүүргийн төсөв	12	692175 м2 талбайн шарилж хог ургамлыг устгах цэвэрлэсэн.	"Шарилжгүй эрүүл дүүрэг аян"-г зохион байгуулж 70,000-аас доошгүй м2 талбайн шарилж хог ургамлыг устгасан байна.	3.0	6.0	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/174 дүгээр тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2023" аяны хүрээнд шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэх их цэвэрлэгээг дүүргийн хэмжээнд "Шарилжгүй Эко дүүрэг" уриан дор 2023 оны 06 дугаар сарын 30, 08 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулж, 452,652 м.кв талбайгаас 80.3 тонн шарилж хөл газрын ургамлыг цэвэрлэж, хяналт тавьж ажилласан.	100%
Шаардагдах төсөв							70,782			5,516.0	1,706.4		
2.3. Цар тахлын үеийн бэлэн байдал													
2.3.1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.	52	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ОБХ, ЭМТ, ХУДНЭ, ЦГ	Хороод	Дүүргийн төсөв	800	Хариу арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай нөөцийг бүрдүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	-		Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжинэ	-
2.3.2 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, заавар, зөвлөмж өгөх замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.	53	Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ХүХҮХ	ОБХ, Хороод	-	-	Хүнсний худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний 1600 аж ахуйн нэгж байгууллага халдвар хамгааллын дэглэм мөрдөн ажиллаж байна.	Худалдаа, үйлчилгээний 1600-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллана.	-		Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжинэ	-
2.3.3 Гамшгийн үеийн бэлэн байдалтай холбоотой Хүнсээр хангах албаны мэргэжлийн ангийн тоог нэмэгдүүлж, хүнсний хангамжийг тогтворжуулна.	54	Дүүргийн Хүнсээр хангах албаны төлөвлөгөөнд тодотгол хийж, хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ХүХҮХ	УЗХ	-	-	Хүнс ханган нийлүүлэхээр 27 байгууллагатай гэрээ байгуулсан.	40-аас доошгүй аж ахуйн нэгжтэй болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээ байгуулж, шаардлагатай хүнсний нөөцийг бүрдүүлсэн байна.	-		Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжинэ	-

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.3.4 Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан тохиромжтой худалдан борлуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	55	Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.	Бэлэн байдлыг н зэрэгт шилжсэн хугацаанд	ХҮХҮХ, ЖДҮТТ	УЗХ	-	-	2020 онд нөөцийн махны өргөтгөсөн худалдаа 2 удаа 5 байршилд зохион байгуулсан.	Иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн 2-оос доошгүй удаа худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.	-	-	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжинэ	-
Шаардагдах төсөв							800			-	-		
2.4. Хотын соёл													
2.4.1 Бүх шатны боловсрол соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлэх	56	"Монгол үндэсний бахархлын өдөр"-ийг тохиолдуулан "Иргэний андгай өргөх ёслол"-ыг зохион байгуулах	2021-2024	НХХ, СО, ГБХЗХХ	УБХ	Дүүргийн төсөв	4	135 сурагчийг хамруулсан.	30 сурагч хамруулн	1.0		Улс тунхагласны 99 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын Иргэний үнэмлэх гардуулах, андгай өргөх" ёслолын үйл ажиллагаанд Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 19 сургуулийн 80 сурагч оролцож, иргэний үнэмлэх гардан авсан.	80%
	57	"Хотын соёл" цуврал контент, видео шторк бэлтгэх, цахим аяныг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2024	НХХ, СО, ГБХЗХХ, АБНТБТ	Нийт байгууллага	-	60	Сургалт, өдөрлөг нийт 9 нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.	Цуврал контент, видео шторк 3-аас доошгүй нэмэгдүүлсэн байна.	15.0		"Хотын соёл-Хорт зуршил" сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 6 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн нийт 1045 оюутан хамруулж, "Хотын соёл - Бидний үйлдэл" сэдэвт илтгэлийн уралдаанд 1, 2 дугаар дамжааны 15 багийн 75 оюутан, 6 удирдагч багш оролцсон. Соёлыг түгээн дэлгэрүүлэх, бусдад эерэгээр нөлөөлөх, соёлтой харилцааг дэмжихэд чиглэгдсэн "Биеэ зөв авч явах соёл" сэдэвт сургалтаар төр, хувийн хэвшлийн нийт 7 байгууллагад 7 удаагийн сургалтаар 206 иргэнийг хамруулсан. Хотын соёл" аяны хүрээнд хотын соёлыг түгээх 5 бичлэг, 18 постерыг төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн пэйж хуудас болон иргэд, байгууллагын албан хаагчдын группт байршуулснаар 3986 иргэн хандаж, 327 лайк дарж, 154 шэйр хийгдсэн байна.	100%
2.4.2 Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс үндэсний бахархал, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж хэвшүүлнэ.	58	Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд болгон дахь соёлын өв сэдэвт олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна.	2021-2024	НХХ, АБНТБТ		Дүүргийн төсөв	4	2 удаагийн үйл ажиллагаанд 100 хүнийг хамруулсан.	100-аас доошгүй хүнийг хамруулна.	12.4	3.7	"Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн хүрээнд иргэд, хүүхэд, залуучуудад соёлын өвийн боловсрол олгох, соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, үндэсний бахархал, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Богцон дахь соёлын өв" төслийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд "Өв соёлоо танин мэдье" сэдэвт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, төрийн өмчийн ерөнхий боловсролын 23 сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 6 төв, 25 хорооны иргэд нийт 1081 хүнийг хамруулсан. Сургалтад хамрагдсан оролцогчдын дунд цахим контент болон бүтээлийн уралдаан зарлаж, шилдэг оролцогчдыг шагнаж урамшууллаа. Иргэд, хүүхэд, залуучуудын соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Өв соёл-Эко дүүрэг" 1800 гаруй гишүүнтэй цахим хуудсыг нээж, мэдээ мэдээллийг тогтмол хүргэж ажилласан.	100%
	59	Дүүргийн хүүхэд, залуучуудыг үндэсний дуу, хөгжим, бүжгийн сургалтад хамруулна.	2021-2024	НХХ, СО	Хороод	-	-	4 төрлийн сургалтад 100 хүнийг хамруулсан.	100-аас доошгүй хүнийг хамруулна.	-		Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2023-2024 оны хичээлийн жилд нийт 166 хүүхэд сургахаар төлөвлөнөөс Морин хуур хөгжмийн сургалтад-35, Төгөлдөр хуур хөгжмийн сургалтад- 56, Ёочин хөгжмийн сургалтад-5, Ятга хөгжмийн сургалтад-5, Бужгийн сургалтад-34 хүүхэд бүртгүүлсэн бөгөөд Морин хуур хөгжмийн сургалтад-1, төгөлдөр хуур хөгжмийн сургалтад-2, Бүжгийн сургалтад-1, хөгжлийн бэрхшээлтэй нийт 4 хүүхдийг үнэ төлбөргүй сургалтад хамруулсан. Нийт 139 суралцагчийг насны ангиллаар нь авч үзвэл 7-16 насны 136, 17-34 насны 2, 35-54 насны 1 суралцагч байгаа бол эмэгтэй -93, эрэгтэй-46 байна.	100%
	60	Түүх, соёлын үл хөдлөх өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.	2021-2022	НХХ, СО	Хороод	Нийслэл, дүүргийн төсөв	200	Дүүрэгт сэргээн засварлах шаардлагатай 3 соёлын өв байна.	Сэргээн засварлах хамгаалалтад авах шаардлагатай соёлын өвийн судалгааг шинэчилнэ.	50.0	40.6 Дүүргийн төсөв	Дүүрэг дэх соёлын үл хөдлөх өвийн шинэчилсэн судалгаагаар улсын хамгаалалтад 2, нийслэлийн хамгаалалтад 4, дүүргийн хамгаалалтад 39 нийт 45 түүх, соёлын үл хөдлөх өв хадгалагдаж байгаа бөгөөд шинэчилсэн судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 07/525 нийслэлийн Захирагчийн ажлын алба болон Соёл урлагийн газарт хүргүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 50 жилийн ойн өндөрлөг болон орчны талбайн тохижилт, "Чингис хааны сэргэ дүрийг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2 дугаар хороо "Ажилчны алдар талбайн засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр "Хан билүү" ХХК шалгарч, талбайг соёлын чулуугаар хучих, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	61	Дүүргийн Соёлын ордны барилгыг шинээр барих ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2022-2024	ТГУХ, НХХ, СО	НСУГ	Улс, нийслэлийн төсөв	8,500	Хуучин барилгын ашиглалтын шаардлага хангахгүй дүгнэлт гарсан.	Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлж, барилгын ажлын явц 30 хувьд хүргэнэ байна.	-		2020-2023 онд барилгын зураг төсвийн зардал болон угсралтын зардлыг улс, нийслэлийн төсөвт тумгуулах санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.	0%
Шаардагдах төсөв							8,768			78.4	44.3		
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ							92,197			13,768.5	3,367.9		87%
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ													
3.1 Иргэн төвтэй үйлчилгээ													
3.1.1 Иргэдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалт бүхий хөгжлийн төвүүдийг нээн ажиллуулна.	62	Ахмад залуучуудын болон иргэдийн хөгжлийн төвийн барилгыг барьж байгуулах ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2023	ТГУХ, НХХ	ГЗБА, ГБХЭХХ, Хороод	Улс, нийслэлийн төсөв	2,100	4 хороонд ахмадын хөгжлийн төв ажиллуулж байна.	-	-		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иргэдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалттай Иргэдийн хөгжлийн болон Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын 3 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд 5 дугаар хорооны Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлын явц 95 хувьтай, Улсын комиссод хүлээлгэж өгөхөөр бэлтгэл хангуулж байна. 12 дугаар хорооны Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн барилгын каркас цутгалт, давхар хоорондын өрлөг дүүргэлт хийгдэн ажлын явц 80 хувь; 16 дугаар хорооны Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын каркас цутгалт, давхар хоорондын өрлөг дүүргэлт хийгдэн ажлын явц 70 хувьтай тус тус үргэлжилж байна. Тус барилгууд 2024 оны 2-р улиралд ашиглалтад орно.	90%
3.1.2 Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Чанарын удирдлагын тогтолцоо"-г нэвтрүүлэх ажил зохион байгуулж, хороодын үйл ажиллагааны чадавхийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Хороодын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	63	"Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ"	2022-2023	ТЗУХ	ЗДТГ-ын хэлтсүүд, Хороод	Дүүргийн төсөв	30	-	"Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандарт нэвтрүүлсэн байна.	10.0	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн удирдлага дор Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн ISO 23592:2021 стандартыг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ний хооронд дүүргийн 22, 23, 25 дугаар хороодод хэрэгжүүлж, "Монсерфт" Тохирлын үнэлгээний байгууллагын баталгаажуулалтын зөвлөлийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн D-23/049 дүгээр тогтоолоор стандарт нэвтрүүлсэн анхдагч гэрчилгээ 22, 23 дугаар хороонд 1 жил, 25 дугаар хороонд 3 жилийн хугацаатайгаар олгогдсон.	100%
	64	Хороодын хөгжил дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	ТЗУХ	НХХ, ТНААХ	Дүүргийн төсөв	117	-	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 60 хувь.	-	258.9	Хорооны хөгжил дэд хөтөлбөрийн хүрээнд 5 зорилтын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 14 арга хэмжээний хэрэгжилт 91 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн онцлог ажлуудаас дурдвал: •Хороодыг техник хэрэгслээр хангах" зорилтын хүрээнд дүүргийн 25 хорооны нийгмийн ажилтны компьютерийг шинэчилсэн; •Төрийн үйлчилгээний батлагдсан стандартыг хэрэгжүүлэх, хороодын Засаг дарга нарын цахимаар үзүүлэх үйлчилгээний төрөл, арга хэлбэр, албан хаагчдын үр чадварыг нэмэгдүүлэх 2 зорилтын хүрээнд дүүргийн 2, 3, 8, 9, 10, 12, 13, 16, 19, 21 дүгээр хорооны албан хаагчдын хувцаслалтыг жигдрүүлж, үр чадвар нэмэгдүүлэх 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 390 албан хаагч хамруулж, дүүргийн 22, 23, 25 дугаар хороодын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн MNS ISO 23592:2021 стандартуудыг нэвтрүүлэн, баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан; •Ногоон байгууламж, тоглоомын талбай бүхий "Эко" хороог бий болгох зорилтын хүрээнд дүүргийн 12, 19, 21 дүгээр хорооны цогцолбор байрыг налуу шаттай болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн.	90%
Шаардагдах төсөв							2,247			10.0	258.9		

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
3.2. Ухаалаг төрийн үйлчилгээ													
3.2.1 Дүүргийн иргэд болон гадаадад амьдарч байгаа иргэдэд зориулж төрийн үйлчилгээг хялбаршуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мобайл аппликейшнийг хөгжүүлэн, цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	65	Мобайл аппликейшнийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ	2022-2024	ТЗУХ		-	55	Мобайл аппликейшний хөгжүүлэлт хийгдсэн.	4 үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна.	15.0		Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Цахим хөгжил, мэдээллийн технологийн газартай хамтран Хан-Уул дүүргийн 25 хорооны 230 хэсгийн ахлагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд "Дижитал сити" аппликейшний хэрэглээг нэвтрүүлсэн. Хэсгийн ахлагч нар иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхээр орчны зөрчил, гомдол, мэдээллийг аппликейшний тусламжтай 44 зөрчил бүртгэн холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлээд байна.	100%
3.2.2 Засаг захиргааны анхан шатны нэгж хорооноос иргэдэд хүргэж буй үйлчилгээний төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлж, зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	66	Хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ	2021-2023	ТЗУХ	УБХ, ХөХҮХ Хороод	-	1 хороонд УБХ-ийн 4 төрлийн үйлчилгээ үзүүлдэг.	2-5 хороонд 5-9 төрлийн үйлчилгээ үзүүлнэ.		-		Хан-Уул дүүргийн 21 хороонд 12 нэр төрлийн улсын бүртгэл хийгдэж байгаа бөгөөд эрх зүйч мэргэжилтэй Улсын бүртгэгч нарыг Дотоод хэргийн Их сургуульд сургалтад хамруулснаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн зарим нэр төрлийг 8 хороонд нэвтрүүлэхээр бэлтгэл хангаж байна. ХурДан" төрийн үйлчилгээний цэгийг Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо Нисэхийн "Хан Плаза" төвийн хоёрдугаар давхарт нээснээр Нисэх, Яармаг бүсийн 70-100 гаруй мянган иргэн лавлагаа тодорхойлолтын 94, нэг шатлалт үйлчилгээний 55, олон шатлалт үйлчилгээний 291 нийт 440 төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн. 18 дугаар хорооны иргэний танхимыг тохижуулж Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээний төвийг 2023 оны 10 дугаар сараас нээн ажиллуулж эхэлснээр иргэн, хуулийн этгээд, өмч хөрөнгөтэй холбоотой улсын бүртгэлийн 24 нэр төрлийн үйлчилгээг 11,15,17,18,19,22 дугаар хорооны 85 мянган иргэдэд хүргэж байна. Үүнээс гадна; -Нийгмийн халамжийн үйлчилгээ бүрэн цахим хэлбэрт шилжиж, Ehalamj.mn програмаар дамжуулан иргэдэд 69 нэр төрлийн үйлчилгээ үзүүлж байна. -Газрын харилцаатай холбогдолтой 36 төрлийн үйлчилгээг egazar.gov.mn цахим хуудас, egazar аппликейшн, emongolia цахим систем болон 25 хороонд суурилуулсан киоск машины тусламжтайгаар иргэд татвар хураамж, лавлагаа, торгууль, төлбөр тооцоо гэх мэт төрийн болон бизнесийн байгууллагын нийт 174 нэр төрлийн үйлчилгээг цахимаар авч байна.	100%
3.2.3. Дүүргээс аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	67	Цахим бүртгэлийн системд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулна.	2021-2024	ХүХҮХ	Нийт байгууллагууд		"Хан-Уул эко дүүрэг" цахим системд 1100 иргэн, аж ахуйн нэгж.	Цахим санд нийт аж ахуйн нэгж байгууллагын 70-аас доошгүй хувийг хамруулна.		-		Цахим хөтөлбөрийн хүрээнд: -Худалдаа, үйлчилгээ эрхлэх "Онлайн бизнес төв" цахим бүртгэлийн системд 2023 онд нийт 1172 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 99%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. "Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл" гаргуулахаар 538 байгууллага материал бүрдүүлж, "E-Mongolia"-д хүсэлт илгээснийг Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар хүлээн авч, холбогдох журмын дагуу MNS 6423:2015 стандартын шаардлага хангасан эсэхийг шалган 100 хувь шийдвэрлэсэн. Дүүргийн нутагт дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 24378 татвар төлөгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэйгээс 24216 буюу 99.3 хувь нь ИТАХ цахим бүртгэлд хамрагдаж цахим системээр татвар төлж байна.	90%
3.2.4 Захын болон алслагдсан гэр хороолол, амралт зугаалгын бус, иргэд олноор цуглардаг газруудад утасгүй интернетиин сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ.	68	Иргэд олноор цуглардаг бүсүүдэд утасгүй интернетийн сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2022-2024	ТЗУХ, ТГУХ	Хороод	Дүүргийн төсөв	2020 онд 4 байршилд утасгүй интернетийн сүлжээ суурилуулсан.	2 байршилд утасгүй интернетийн сүлжээ суурилуулна.		25.0		Хан-Уул дүүргийн 4, 7, 8, 21 дүгээр хорооны цогцолбор байранд утасгүй интернэт суурилуулж тус хороодоос төрийн үйлчилгээ авч буй 3000 гаруй иргэдэд үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөл бүрдсэн. Мөн 8 дугаар хорооны Дэнжийн цэцэрлэгт хүрээлэн, 22 дугаар хорооны Дугуй цагаан орчимд утасгүй интернэтийн сүлжээ байгуулах тоног төхөөрөмжийн судалгааны ажил хийгдэж байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)			
3.2.5 Дүүргийн худалдаа үйлчилгээний цэг салбарыг нэгдсэн цахим системд оруулж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгоно.	69	Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хийх гэрээ, олгох батламжийн үйл ажиллагааг цахимжуулна.	2021-2022	ХүХҮХ, ААӨХ	ЖДҮДТ, Хороод	-	-	-	Цахимаар гэрээ батламж олгох үйл ажиллагаа 70%-д хүргэнэ.	-	-	Худалдаа үйлчилгээ эрхлэх "Онлайн бизнес төв" цахим бүртгэлийн системд 2023 онд нийт 1172 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 99%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Үүнд: -Шийдвэрлэсэн-851 -Судалж буй- 11 -Татгалзсан-310 Мөн худалдаа үйлчилгээ эрхлэх "Онлайн бизнес төв" цахим бүртгэлийн системийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд танилцуулан, зөвлөгөө мэдээлэл өгсөн. "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн хурлаар тамхи худалдах тусгай зөвшөөрөл хүссэн 101 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хэлэлцэж, 63 иргэн, аж ахуйн нэгжид тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон.	100%	
Шаардагдах төсөв							130			40.0	-			
3.3. Мэргэшсэн тогтвортой төрийн алба														
3.3.1 Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулна.	70	Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, дотоод болон гадаадын богино, дунд хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлнэ	2021-2024	ТЗУХ	Нийт байгууллагууд	Дүүргийн төсөв	200		2020 онд 49 албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.	25 албан хаагчийг сургалтад хамруулж мэргэжил, үр чадварыг дээшлүүлнэ.	75.0	1,040.0	Засаг даргын Тамгын газар болон хорооны албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 3, чиглүүлэх дунд хугацааны сургалтад 1, "А3" гэрчилгээ олгох сургалтад 13, архив, албан хэрэг хөтөлбөрийн мэргэшүүлэх дунд хугацааны хөтөлбөрт 3, Төрийн албан хаагчдад зориулсан үндэсний бичгийн сертификат олгох сургалтаар 29 албан хаагчдыг хамруулж, нийт 5 төрлийн мэргэшүүлэх сургалтаар 37 албан хаагч сертификат авсан бол бусад цаг үеийн шинжтэй 18 төрлийн сургалтад давтагдсан тоогоор 930 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн "7-4-10" 4 удаагийн цахим сургалтад албан хаагчдыг тухай бүр идэвхтэй хамруулсан.	100%
	71	Төрийн албаны тухай хууль болон холбогдон гарсан журмын хүрээнд бүтэц орон тоог шинэчлэн баталж, ажлын уялдаа холбоог сайжруулна.	2021-2022	ТЗУХ					Бүтэц орон тоо шинэчлэн батлаагүй.				Дүүргийн Засаг даргын 2023 оны А/104 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, албан тушаалын жагсаалтыг шинэчилсэн бөгөөд Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/23 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг тус тус баталсан. Ингэснээр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1058 дугаар захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт нийцүүлэн 10 хэлтэс, 3 тасагтайгаар шинэчлэгдсэн бүтцээр үйл ажиллагаа явуулж байна.	100%
3.3.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана.	72	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчдыг авилгаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулж, дүүргийн цахим хуудас, болон хороодоор дамжуулан авилгаас ангид байх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	ТЗУХ	Нийт байгууллагууд	Дүүргийн төсөв	10		2020 онд 2 удаагийн сургалтад нийт 49 албан хаагчдыг хамруулж, 3 контент байршуулсан.	2 удаагийн сургалт зохион байгуулж, 2 контент байршуулна.	3.0		Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулан сурталчилсан. Шуудрага ёс, хөгжил дэвшилд уриатай "Авлигыг мэдээлэх утас 110" постерийг байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, "Авлигатай тэмцэх таван "Ш" ажиллагаа"-ны "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан Авлигатай тэмцэх газрын "...НЭГДБЕ" соён гэгээрүүлэх аянд нэгдэж тв шторк, постерийг байгууллагын сайт, Хан-Уул Эко дүүрэг албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан 1180 ширхэг зурагт хуудас, 1000 ширхэг тараах материал, 500 ширхэг стикерийг хүн амын төвлөрөл ихтэй байршуулахад байрлуулж, олон нийтэд сурталчилсан. Мөн авлигатай тэмцэх газартай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж нийт 104 төрийн албан хаагч, 80 иргэн, ажилтнуудыг хамруулсан. "Мэдье, Нэгдье" аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ЗДТГ-ын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 10 арга хэмжээний биелэлт 85 хувьтай үргэлжилж байна.	100%
3.3.3 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэлээр, ёс зүй, сахилга хармуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хармуцлагыг чангатгана.	73	Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг харгалзан, холбогдох журмын дагуу үнэлээг тооцож, цахим хуудаст ил тод мэдээлнэ.	2021-2024	ТЗУХ	Нийт байгууллагууд				Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.				Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулан албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх үүрэг бүхий "Үнэлгээний баг"-ийг ЗДТГ-ын даргын 2021 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд холбогдох журмын дагуу 2023 оны хагас жилийн байдлаар ЗДТГ-ын 65, хорооны 39, нийт 104 албан хаагчийн "Хандлага, ёс зүй, үр чадварын үнэлгээ"-г 0-15 оноогоор тооцож, дүнлэгдэн тусгасан. ЗДТГ-ын даргын 2023 оны 11 сарын 17-ны А/94 дүгээр тушаалаар "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд ЗДТГ-ын даргын 2023 оны А/97 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг томилж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хармуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх талаар нийт албан хаагчдад яаналт тавьсан. Тайлант хугацаанд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн 2 удаагийн хурлаар 6 албан хаагчид холбогдох 7 иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэж ёс зүйн зөрчил тогтоогдсон 1 албан хаагчид зөвлөлийн шийдвэрээр холбогдох арга хэмжээ авч тайлант www.khanuul.mn цахим хуудаст байршуулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
3.3.4 Засаг захиргааны анхан шатны нэгж болох хороог ажлын албатай болгон санхүүгийн хувьд бэхжүүлснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	74	Хороодыг ажлын албатай болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2022-2023	ТЗУХ, СТСХ	Хороод	-	-	-	-	6,700.0	Төсвийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16.4 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 08 дугаар тогтоолд хорооны үйл ажиллагааны зардал 8.55 тэрбум төгрөгийн төсвийг батлуулж, тайлант хугацаанд 6.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон хорооны хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	100%	
Шаардагдах төсөв							210			78.0	7,740.0		
3.4 Иргэдийн аюулгүй, амар тайван байдал													
3.4.1 Авто замын шаардлагатай бүс, гэр хорооллын гудамж талбай болон орон сууцны хорооллуудын эмзэг бүсийг хяналтын камерын системд бүрэн хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	75	Хороодын нутаг дэвсгэрийг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2021-2022	ТГУХ, ТНААХ, ЦГ, НҮА ОНӨААТ ҮГ	ЦГ, ЗЦХ, Хороод	Улс, нийслэл, дүүргийн төсөв	2,000	Дүүргийн нутаг дэвсгэрт 1435 ширхэг камер байна.	Нийтийн эзэмшлийн талбай болон ААНБ-удын орчинд 100-аас доошгүй камер суурилуулсан байна.	226.0	1175.5 ДОНХС	Нийслэл, дүүргийн тусвийн хөрөнгөөр Нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах 8 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд: Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжиж буй "Камержуулалт 12, 13, 14 дүгээр хороо" төсөл арга хэмжээний хүрээнд 40 ширхэг камер суурилуулагдах бөгөөд ажлын гүйцэтгэгч шалгарч, зураг төсөл боловсруулах шатанд хэрэгжиж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023-2024 онд хэрэгжих камержуулалтын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажлын хүрээнд 9, 10, 16, 21 дүгээр хороодод 314 ширхэг камер суурилуулагдах бөгөөд худалдан авах ажиллагааны шатанд, "Камерын хяналтын төв рүү шилэн кабель татах, засвар хийх" төсөл арга хэмжээний хүрээнд худаг сувагчлалын ажил хийгдэж шилэн кабель татах ажил хийгдэж, серверийн өрөөний засвар тохижилт хийх төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 70%, "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт" төсөл арга хэмжээний хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодод тусгай зориулалтын камерын шилэн кабель татах, 10 ширхэг камер суурилуулах, ажил хийгдсэн ажлын явц 95 хувьтай тус тус хэрэгжиж байна. Хяналтын цэгүүдийг камерын хяналтын төвд холбох ажил хүлээгдэж байна. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжиж буй "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 4-10, 12, 13, 14, 16, 21 хороо" төсөл арга хэмжээний хүрээнд 80 ширхэг камер суурилуулагдах бөгөөд ажлын гүйцэтгэгч шалгарч, гэрээ байгуулсан, зураг төсөл боловруулах шатанд, 2020-2023 онд хэрэгжиж буй "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 1, 2, 3, 6, 7, 8, 17, 19 хороо" төсөл арга хэмжээний хүрээнд 53 ширхэг камер суурилууллагдсан бөгөөд ажлын гүйцэтгэл 95%. 2021-2023 онд хэрэгжиж буй "Камержуулалт 1-5, 9-11, 13-21 хороо" төсөл, арга хэмжээний хүрээнд 117 ширхэг камер суурилууллагдсан бөгөөд ажлын гүйцэтгэл 95%-тай тус тус хэрэгжиж байна. Хяналтын цэгүүдийг камерын хяналтын төвд холбох ажил хүлээгдэж байна. Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ 1110 ширхэг гудамжны камерын хэвийн ажиллагааг хангахын зэрэгцээ, эвдэрч ажиллагаагүй болсон 98 ширхэг камерыг шинэчилж, 192 камерын гэмтлийг засварласнаар нийт 1208 ширхэг гудамжны камер хэвийн ажиллаж байна.	100%
3.4.2 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	76	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2021-2024	ХЭЗХ, ЦГ				50 хэв журмын урамшуулалт эргүүл 25 олон нийтийн цагдаа 15 оюутан цагдаа ажилласан.	50 хэв журмын урамшуулалт эргүүл 25 олон нийтийн цагдаа 15 оюутан цагдаа ажилласан байна.	-	23.5	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Олон нийтийн цагдаагийн цалин урамшуулалт тогтоох тухай" 03 дугаар тогтоолоор Хан-Уул дүүрэгт 21 олон нийтийн цагдаагийн орон тоо батлагдсан. Олон нийтийн цагдаагийн 7 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлаж, болзол шалгуур хангасан 2 иргэнийг цагдаа мэргэжил олгох сургалтад хамруулж цагдаагаар томилон ажиллуулснаар нийт 16 олон нийтийн цагдаа ажиллаж байна. Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан их, дээд сургуулийн оюутан, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн арга хэмжээ 2, хэсэгчилсэн арга хэмжээ 2, тусгай арга хэмжээ 3-ыг тус тус зохион байгуулж, 6 оюутан эргүүлийг ажиллуулсан. Хамтран ажиллах гэрээний хүрээнд Орхон их сургуулийн бакалавр хөтөлбөрийн цахим ангид 1, Монголын үндэсний их сургуулийн эрх зүйн эчнээ ангид 2 олон нийтийн цагдаагийн ажилтанг суралцуулж байна. Тайлант хугацаанд 8 оюутан эргүүл, цагдаагаар ажилласан.	70%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
3.4.3 Иргэд, өсвөр үе, залуучуудыг согтууруулах, мансууруулах бодисын хор уршиг мэдлэг олгох хичээлийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж сурталчлах	77	Согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг мэдлэг олгох хичээлийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж сурталчлах	2021-2024	ХЭЗХ, ГБХЭХХ, ЦГ, ЭМТ, АБНТБТ	Хороод, ЕБС-ууд	Дүүргийн төсөв	3	5 удаагийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж нийт 348 сурагч хамруулсан.	9 удаагийн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж нийт 900 сурагч хамруулсан байна.	0.9	1.7	“Электрон тамхины хор нөлөө”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Үе тэнгийн гадуурхалт”, “Хүүхэд хамгаалал”, “Цахим болон бусад орчинд өөрийгөө хамгаалах” “Архины хор уршиг” “Мансууруулах бодисын хор хөнөөл”, “Архины хор хөнөөл” “Тамхинаас татгалзъя”, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх нь”, “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх” зэрэг 15 сэдвээр 68 сургалт, 4 аян, 5 өдөрлөг байгуулсан. Сургалт арга хэмжээнд 20 ерөнхий боловсролын сургууль, 11 их дээд сургуулийн давхардсан тоогоор нийт 12682 иргэн хамруулж, 6 төрийн, 2 төрийн бус байгууллага, 132 цагдаагийн албан хаагч хамтран ажилласан. Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлэгсдээс 58 иргэнийг тамхинаас гаргах эмчилгээнд хамруулсан. “Архичид амилахуй” төрийн бус байгууллага, Цагдаагийн 1, 2-р хэлтэстэй хамтран “Эрүүлжүүлэх байр”-нд эрүүлжүүлэгдсэн 215 иргэнд 9 удаа сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч, “Гэртээ харих зам” хөтөлбөрийн хүрээнд 26, удаа дараа саатуулагдсан 108, нийт 134 хүнийг нарийн мэргэжил /дотор, мэдрэл, гэмтэл, мэс засал, сүрьеэ, эмгэгтэйчүүд, лаборатори, зүрх судас/-ийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 158 гэр бүлийн 308 иргэнд хамтарсан багаар дамжуулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн. Мөн Нийслэлийн эрүүл мэндийн газрын Аддиклогийн төв, ТВ-9 телевизийн мөрөөдөл биелдэг юм нэвтрүүлэгтэй хамтран 9 дүгээр хорооны 1 иргэнийг хүсэлтээр нь “Та амьдарлаа өөрчилмөөр байна уу” төсөлд хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн орчинд гэмт хэрэгт өртөж хохирсон эрсдэл өндөртэй 55 сурагчаас судалгаа авч, хар тамхи, мансууруулах бодис, газ /хий/, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж байсан 2 хүүхэдтэй уулзаж, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Хүүхдийг эрсдэлд өртөхөөс сэргийлэх зорилгоор сургууль,цэцэрлэг, ойр орчимд 7 хүүхэд хамгаалагчийг өдөр бүр 4 цагаар хуваарь гарган ажиллуулж байна.	100%
	78	Цахим сүлжээ ашиглан хар тамхи, мансууруулах бодисоос хүүхэд, залуучуудыг сэрэмжлүүлэх зорилго бүхий оюутан, залуусын дунд мэдээ мэдээлэл, сурталчилгаа явуулна.	2021-2024	НХХ, ХЭЗХ, ЦГ, ГБХЭХХ					Цахим сүлжээнд мэдээ мэдээллийг тогтмол оруулна.				“Архичид согтуурахаас сэргийлэх” мэдээлэл сургалт, сурталчилгааны цахим аяныг зохион байгуулж, “Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэх”, Архийг зөв зохистой хэрэглэцгээ! “Архийг хэтрүүлэн хэрэглэх нь хортой”, “Баасан гараг тэмдэглэлт өдөр биш #намайг_алгас”, “Яагаад архи, согтууруулах ундааны хэрэглээ их байна вэ? Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ”, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисоос хүүхэд, залуучуудыг сэрэмжлүүлэх зорилгоор “Мансуураагүй ирээдүйн төлөө” зэрэг 17 төрлийн архи, согторуулах ундааны хор хөнөөлийн талаар ухуулан таниулах постер, мэдээллийг телевиз, цахим сайтад тус тус байршуулж, 52364 иргэнд хүргэсэн.
3.4.4 Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах “Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэлийг бууруулна.	79	Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах “Хүүхэд хамгаалагч” төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2021-2024	НХХ, ГБХЭХХ, ЦГ, БХ	Хороод, ЕБС, СӨБ	Улсын төсөв	65	Хүүхэд хамгаалагчаар 21 хүн ажилласан.	Хүүхэд хамгаалагчаар 21 хүн ажилласан байна.	16.2	9.8	Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн санхүүжилттэй “Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран 4 дүгээр сард 13, 5 дугаар сард 8 нийт 21 хүүхэд хамгаалагч хүүхдийг гэмт хэрэг зөрчил, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрэхээр ажиллаж байна. Хүүхэд хамгаалагч нарт урамшуулал 9,8 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хүүхэд хамгаалагч нар нь хүүхэд, иргэд, олон нийтээс ирүүлсэн 3 мэдээ, мэдээллийг Цагдаагийн газарт мэдэгдэн холбон зуучилснаар гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй 4 хүүхдийг бүртгэлд авсан. Мөн хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 8 сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуулиудын мэдээллийн самбарт байршуулж, нийт 65 удаагийн сургалтад давхардсан тоогоор 3680 сурагч, асран хамгаалагч, багш нарыг хамруулан холбогдох мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан.	100%
Шаардагдах төсөв							2,070			243.1	1,210.5		
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ							4,657			371.1	9,209.4		97%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ													
4.1. Боловсрол													
4.1.1. Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүрээнд 20-иос доошгүй сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	80	Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, НХХ, БХ		Улс, нийслэл, дүүргийн төсөв	79,372	2020 оны байдлаар нийт цэцэрлэг, сургуулийн хүртээмж 13740 суудал, 5810 ор тус тус байна.	2 сургууль буюу 1200 суудал, 2 цэцэрлэг 280 ороор нэмэгдэнэ.	18,200.0	УТХО 16536.8 НТХО 6800	Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийт 3360 орны хүчин чадалтай 19 цэцэрлэгийн барилгын ажил хэрэгжиж байгаагаас улсын төсвийн хөрөнгөөр 1490 орны хүчин чадалтай 8, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1070 орны хүчин чадалтай 6, дүүргийн төсвийн хөрөнгөөр 650 орны хүчин чадалтай 4, гадаадын зээл тусламжаар 150 орны хүчин чадалтай 1 цэцэрлэгийн барилгын ажил тус тус хэрэгжиж байна. Үүнд; Дүүргийн 3-р хороо, 100 ортой 322-р цэцэрлэгийн барилга /худалдан авсан/, 4-р хороо, 200 ортой 31 цэцэрлэгийн барилга, 9-р хороо, 240 ортой 134-р цэцэрлэгийн барилга, 11-р хороо, 150 ортой 32 цэцэрлэгийн барилга /худалдан авсан/, 21-р хороо, 100 ортой 326-р цэцэрлэгийн барилга /худалд авсан/, тус тус ашиглалтад орж, 15-р хороо, 200 ортой цэцэрлэгийн барилга улсын комисс хүлээн авах шатанд байгаа бөгөөд нийт 1090 орны хүчин чадалтай 6 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж байна. Дүүргийн 16-р хороо, 200 ортой цэцэрлэгийн барилгын барилга 95 хувь, 5-р хороо, 150 ор бүхий 7 цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 50 хувь, 1-р хороо, 120 ортой 67 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 50 хувь, 1-р хороо, 240 ортой цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын явц 40 хувь, 2-р хороо, 150 ортой 72-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 50 хувь, 4-р хороо, 100 ортой 145 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 40 хувь, 8-р хороонд 240 ортой цэцэрлэгийн барилгын ажлын явц 25 хувь, 9-р хороо, 50 ортой цэцэрлэгийн барилгын газар чөлөөлөлт хийгдсэн, зураг төсөв боловсруулагдаж байна. ажлын явц 5 хувь, 10-р хороо, 240 ортой 49 дүгээ цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажил явц 50 хувь, 16-р хороо, 240 орт цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын явц 50 хувь, 18-р хороо, 200 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулагдаж байна. ажлын явц 5 хувь, 20-р хороо, 240 ортой цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын явц 40 хувь, 4-р хороо, 240 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулагдаж байна. ажлын явц 5 хувьтай тус тус хэрэгжиж байгаа бөгөөд нийт 2170 ортой 12 цэцэрлэгийн барилга 2024 онд бүрэн ашиглалтад орно.	100%
4.1.1. Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүрээнд 20-иос доошгүй сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, НХХ, БХ		Улс, нийслэл, дүүргийн төсөв	2020 оны байдлаар нийт цэцэрлэг, сургуулийн хүртээмж 13740 суудал, 5810 ор тус тус байна.	2 сургууль буюу 1200 суудал, 2 цэцэрлэг 280 ороор нэмэгдэнэ.			Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2023 нийт 5360 хүүхдийн суудалтай 7 сургууль, 1080 суудал, 600 ор бүхий 6 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил хэрэгжиж байгаагаас Улсын төсвийн хөрөнгөөр 4-р хороо 360 суудалтай 34-р сургуулийн өргөтгөлийн барилга, 21 дүгээр хороо 960 суудалтай сургуулийн барилгын ажил, 13 дугаар хороо бага сургууль цэцэрлэгийн цогцолбор /180 суудал, 100 ор/-ын барилгын ажил бүрэн хэрэгжсэн бөгөөд 19 дүгээр хороо 115 дугаар сургуулийн 320 суудал бүхий өргөтгөлийн барилгын ажил дуусч улсын комисс ажлууллах шатанд байна. Ингэснээр 2023 онд нийт 1820 суудалтай 4 сургууль ашиглалтад орж байна. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 4-р хороо 960 суудалтай сургуулийн барилгын ажлын явц 15 хувь, 8-р хороо 640 суудалтай сургуулийн барилгын ажлын явц 30 хувь, 16 дугаар хороо 640 суудалтай сургуулийн барилгын ажлын явц 30 хувь, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 9, 12, 14, 16 дугаар хороодод хэрэгжиж буй /900 суудал, 500 ортой/ 5 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлын явц 10-30% хувь, Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3-р хороо 18-р сургуулийн 320 суудалтай өргөтгөлийн барилгын ажлын явц 60 хувьтай тус тус хэрэгжиж байна. Нийт 2560 суудал бүхий 4 сургуулийн барилга, 900 суудал бүхий 5 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор барилга 2024 онд ашиглалтад орно.		

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.1.2 Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих тэдний тэргүүн туршлагыг түргээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	81	Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ.	2021-2024	НХХ, БХ	ЕБС, СӨБ	Дүүргийн төсөв	105	Үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгагдсан.	Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна.	-	38.3	"Багш" дэд хөтөлбөрийг 1 дүгээр зорилтын хүрээнд 5 төсөл, арга хэмжээ, 2 дугаар зорилтын хүрээнд 5 төсөл, арга хэмжээ, нийт 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: - Багшийн заах арга зүйг хөгжүүлэх чиглэлээр Бүгд Найрамдах Болгар Улсад зохион байгуулагдах "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" Олон Улсын хуралд төлөөлөгч оролцуулах, БНСУ-ын Өмнөд Кёонсанн аймгийн Кёоннам Их сургуультай хамтарсан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, "Боловсролын салбар дахь шинэ санаачилга, шилдэг туршлага" анхдугаар зөвлөгөөн, Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, "Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулиудын багш, ажилчдын спортын 5 төрөлт тэмцээн" зохион байгуулах болон Сургуулийн менежментийг сайжруулах зорилгоор сайн туршлага түгээн дэлгэрүүлэх ажлыг дүүргийн 17 сургуульд зохион байгуулах зэрэг 5 төсөл, арга хэмжээ - Сурагчдын хөгжил төлөвшилийг дэмжих чиглэлээр 15, 75 дугаар сургууль "Амжилт өөд-Алхам алхмаар" 52 дугаар сургууль "Шинэ арга зүй-Шилдэг хичээл", 63 дугаар сургууль "Хүүхэд бүхэн эрхэм", 118 дугаар "Сургалтын өрөөг тохижуулах" 5 төсөл арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн.	75%
4.1.3. Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны үйлчилгээг нэмэгдүүлж, богино эргэлтийн шуурхай автобус бий болгох үйлчилгээг нэвтрүүлнэ.	82	Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны тоог нэмэгдүүлнэ.	2021-2024	НХХ, БХ	ЕБС, СӨБ	Нийслэл, дүүргийн төсөв	-	Төрийн өмчийн 6 сургуульд - 7 автобус	1 автобусаар нэмэгдүүлнэ.	-		Дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 7, 10, 26, 59, 118 дугаар сургуулиудад тус бүр 1 автобус, 63 дугаар сургуульд 2 автобус ашиглагдаж байсан бөгөөд 7, 26 дугаар сургуулийн автобус ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул акталсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 7, 15, 32, 34, 114, 135 сургуульд 6 ширхэг 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 26, 156-р сургуульд 2 шинэ автобус тус тус худалдан авсан. Дүүргийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг нийт 13 автобусаар баталсан маршрутын дагуу 6 рэйсээр 416 хүүхдийн аюулгүй байдлыг ханган үйлчилж байна.	100%
4.1.4 Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох, сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.	83	Сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.	2021-2024	НХХ, БХ	ЕБС-иуд	Нийслэл, дүүргийн төсөв	-	Судалгааны ажил хийгдсэн.	Скүүл Алерт төхөөрөмжийн RFID tag бүхий үнэмлэх эзэмших сурагчдын тоог өмнөх жилээс 5% -аар нэмэгдүүлэх.	-		Төрийн өмчийн ерөнхий боловсролын 17 сургуулийн 1-5 дугаар ангийн 15750 сурагчдад ухаалаг үнэмлэхийг олгосон. Төрийн өмчийн ерөнхий боловсролын 17 сургууль болон автобусны буудал, хүүхэд ихээр зорчдог гудамж талбайд нийт 174 уншигч төхөөрөмжийг байрлуулж, тоног төхөөрөмж ашиглах цахим гарын авлагыг боловсруулснаар эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин ашиглаж байна.	70%
4.1.5 Тусгай хэрэгцээт хүүхдийг эрдийн сургууль, цэцэрлэгт хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.	84	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, ХБХ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2021-2024	НХХ, БХ	ЕБС, СӨБ	Дүүргийн төсөв	-	2 удаагийн сургалтад 200 захирал, эрхлэгчийг хамруулсан.	4 сургалтад 200 багшийг хамруулж 250 хүүхдийг хамруулна.	-		Тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын орчны хүртээмжийг нэмэгдүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор "Боловсролд тэгш хамруулах нь" сургалтад 24 сургууль, 38 цэцэрлэгийн 62 захирал, эрхлэгч нар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 4 удаагийн сургалт давхардсан тоогоор 891 багш, удирдах ажилтан хамрагдсан. 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 520, сургуулийн өмнөх боловсролд 160 хүүхэд хамрагдсан. 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 538, сургуулийн өмнөх боловсролд 205 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тус тус хамрагдаад байна.	100%
Шаардагдах төсөв							79,477			18,200.0	23,375.1		
4.2. Нийгмийн халамж													
4.2.1 Зорилтот өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	85	Зорилтот өрхийн 15-34 насны хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн судалгааг гаргаж, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулна.	2021-2024	НХХ, ХөХҮХ, АБНТБТ	Хороод	ХЭДС	17	179 иргэн.	180 иргэн.	4.2	8.4	2023 онд Дүүргийн ажил хайгч, зорилтот бүлгийн мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдах хүсэлт гаргасан 64 иргэний судалгааг Нийслэлийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлэхийн зэрэгцээ, чадавжуулах зорилгоор компьютерын анхан шатны сургалтад 64, солонгос хэлний сургалтад 62, оёдол эсгүүрийн сургалтад 41, үсчний сургалтад 22 нийт 189 иргэнийг хамруулж, чадамжийн бүрчлгээ олголоо. Зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулах хүсэлт ирүүлсэн 10 сургалтын байгууллагатай гэрээ байгуулж, зардлын 70 хувь 8.4 сая төгрөгийг олгож, 400 залуучуудыг бүртгэн, сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн.	100%
	86	Зорилтот өрхийн иргэдийг ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2021-2024	НХХ, ХөХҮХ		ХЭДС	20	57 иргэн ажлын байранд зуучилсан.	60-аас доошгүй иргэн.	5.0		Дүүргийн хэмжээнд 3200 бүртгэлтэй ажилгүй иргэдийн 487 буюу 15.2 хувь, ажилд зуучлагдсан 800 иргэдийн 203 (25.3%), 15-34 насны залуус байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй-51 (6.3%), хүнсний талонд хамрагддаг өрхийн-11 (13.7%) иргэнийг тус тус ажлын байранд зуучилсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.2.5 Дүүргийн “Эко ахмадын сувилал”-ын барилгыг ашиглалтад оруулж, ахмадууд үйлчлүүлэх амралт, сувиллын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	92	“Эко ахмадын сувилал”-ын барилгыг ашиглалтад оруулна.	2021	ТГУХ, ТНААХ, Эко ахмадын сувилал ОНӨААТ ҮГ		Дүүргийн төсөв	1,334	Барилгын ажил 90%-тай хэрэгжиж байна.	-	-		Хэрэгжиж дууссан.	-
Шардагдах төсөв							2,071			74.0	872.6		
4.3. Хөдөлмөр эрхлэлт													
4.3.1 “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.	93	Халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ыг хөгжүүлж, нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах	2021-2024	ХөХҮХ	НХХ	-	-	6 төрлийн үйлчилгээ нэвтрүүлсэн.	15 төрлийн үйлчилгээ.	-		Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжиж, халамжийн нэгдсэн систем (Ehalamj.mn)-ээр 69 төрлийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтөд 2023 оны 10 дугаар сарын байдлаар нийт 167985 иргэнд 121,477,6 сая төгрөгийг зарцуулсан байна. Шинээр хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээний цахим хөгжүүлэлт хийгдэж байна.	100%
	94	Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг, хуль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	2021-2024	ХөХҮХ	НХХ	Улсын төсөв	50	алт хэлэлцүүлэг зо	3 удаагийн уулзалт хэлэлцүүлэг.	15.0		Соёлын ордон, Хүннү молл, 12, 13, 14-р хорооны иргэний танхимд нийт 5 удаа 400 иргэн хамруулан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г танилцуулах хөдөлмөрийн өдөрлөг яармаг зохион байгуулсан. Өдөрлөг яармагт оролцогчдод төсөл бичих арга зүйн зөвлөгөө өгснөөр дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст нийт 392 төсөл ирүүлснээс 165 төслийг сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 1 тэрбум 70 сая төгрөг олгосон.	100%
4.3.2 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	95	Шилдэг "Старт-ап" 2 багийг сонгон шалгаруулах, Старт-ап залуучуудад ментор хийх	2021-2024	ХөХҮХ	ЖДҮДТ	Улсын төсөв	168	5 баг.	4 баг.	56.0	20.0	Улсын хэмжээнд шинэ технологи, инновац шингээсэн гарааны бизнес эрхэлж буй залуучуудад гарааны санхүүжилт олгох, мэргэжлийн менторууд, бизнес эрхлэгчдээс зөвлөгөө авах, дараагийн шатны санхүүжилт олгох, бизнес санааг нь улсын хэмжээнд сурталчлан таниулах зорилготой шилдэг старт ап шалгаруулах уралдааны зарыг хороодоор дамжуулан түгээнснээр Хан-Уул дүүргийн хэмжээнд 36 залуучууд бүртгүүлж анхан шатны сонгон шалгаруулалтад тус бүр 2 хүнтэй 5 баг шалгарч дараагийн шатны сургалтад 10 залууг хамруулсан. Үүнээс сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 багт тус бүр 10 сая төгрөг буюу 4 залууд 20 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	50%
	96	"Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" бүлгээр ажиллах чадвар олгох сургалт зохион байгуулж гэрчилгээ олгоно.	2021-2024	ХүХҮХ, ХөХҮХ, ЖДҮДТ		Дүүргийн төсөв	-	2020 онд "Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл", сургалтад 36 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан.	40-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамруулна.	-		Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд холбогдох талуудтай 51 залуусыг сургалтад хамруулж, 18-36 насны 20 иргэний төсөлд эргэн төлөгдөх нөхцөлтэй 173 сая төгрөгийн санхүүжилтийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон. Улсын хэмжээнд шилдэг старт ап шалгаруулах уралдааны зарыг хороодоор дамжуулан түгээнснээр Хан-Уул дүүргийн хэмжээнд 36 залуу бүртгүүлснээс анхан шатны шалгаруулалтад тус бүр 2 хүнтэй 5 баг шалгарч дараагийн шатны сургалтад хамруулсан. Үүнээс сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 багт тус бүр 10 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Нийт 61 залууг сургалтад хамруулж, 24 залууд 193 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100%
4.3.3 Цагийн ажлын байрыг дэмжиж нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	97	Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах цагийн ажилд зуучлах	2021-2024	ХөХҮХ	НХХ	Улсын төсөв	5	100 оюутанг цагийн ажилд зуучилсан.	150-аас доошгүй оюутанг цагийн ажилд зуучилна.	1.4		Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолоор баталсан 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-н дагуу Нийслэлийн хөдөлмөр халамжийн газар хариуцсан ажиллахаар болсон. 2023 онд Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 12 аж ахуй нэгж байгууллагын 56 цагийн ажлын байрны захиалгыг бүртгэн, Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газарт тухайн бүрт нь хүргүүлсэн бөгөөд 1012 оюутан цагийн ажил эрхлэхээр бүртгүүлснээс 310 оюутныг цагийн ажилд зуучилсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.3.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон ажлын байрыг дүүргийн ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах замаар нэмэгдүүлнэ.	98	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах	2021-2024	ХөХҮХ, АБНТБТ	НХХ	Улсын төсөв	376	48 иргэний сургалтад хамруулж, 25 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	100-аас доошгүй иргэнийг сургалтад хамруулж, 20 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	104.0		Хөгжлийн бэрхшээлтэй 85 иргэний төслийг хүлээн авч ажлын байртай танилцан сонгон шалгаруулалтад тэнцэн 51 иргэний төсөлд 320.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй 140 иргэнийг хамруулж, ажил хайгч 71 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 22 иргэнийг ажилд зуучилсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түр ажлын байранд зуучилж, нийтийг хамарсан ажилд давхардсан тоогоор 120 иргэнийг ажиллууллаа.	100%
4.3.5 Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бий болсон ажлын байрыг бүртгэж, иргэдийг ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	99	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх	2021-2024	ХөХҮХ		Улсын төсөв	111	700 иргэнийг ажилд зуучилж, 2880 иргэнд зөвлөгөө.	720-оос доошгүй иргэнийг ажилд зуучилж, 2800 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.	27.8		2023 онд 606 аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдоос сул чөлөөтэй 966 ажлын байрны захиалга хүлээн авч, 3200 иргэнийг ejob мэдээллийн санд бүртгэж, 1500 иргэнд ажлын байр санал болгон 800 ажил хайгч иргэдийг ажлын байранд зуучилж ажилласан. Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулахаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй 13 байгууллагад захиалга өгсөн. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй 140 иргэнийг хамруулж, ажил хайгч, зорилтот бүлгийн мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг чадавхжуулах зорилгоор компьютерын анхан шатны сургалтад 64, солонгос хэлний сургалтад 62, оёдол эсгүүрийн сургалтад 41, үсчний сургалтад 22 нийт 189 иргэнийг хамруулж, чадамжийн гэрчилгээ олгохын зэрэгцээ төсөл бичих, орлогын эх үүсвэртэй болох сургалт зохион байгуулсан. Мөн 3 удаагийн хөдөлмөрийн өдөрлөг яармагт оролцсон 400 гаруй иргэдэд төсөл бичих арга зүйн зөвлөгөө өгсөн.	100%
4.3.6 "Хан-Уулд үйлдвэрлэл" борлуулалтын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.	100	"Хан-Уулд үйлдвэрлэл" борлуулалтын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ		Дүүргийн төсөв	48	2020 онд, 24 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг "Түрээсийн төлбөргүй" борлуулсан.	75-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	12.0		Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, борлуулалтыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд Хан-Уулд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих зорилгоор "Бүтээгч Хан-Уулчууд-2023" арга хэмжээг 5 удаа зохион байгуулж нийт 780 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сурталчлан борлуулалтыг нь дэмжсэн. Мөн дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах зорилгоор 20 удаагийн арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 187 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж, нийлбэр дүнгээр 433.0 сая төгрөгийн борлуулалт хийхэд нь дэмжлэг үзүүлсэн. "Хан-Уулд үйлдвэрлэл" борлуулалтын төвийн үйл ажиллагааг дахин нээхтэй холбогдуулан 8 аж ахуйн нэгжээс талбайн хэмжээ, үнийн саналыг авч төслийг боловсруулсан. "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөр батлагдсантай холбогдуулан борлуулалтын төвийг нээх ажлыг түр хугацаанд хойшуулсан.	90%
4.3.7 Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	101	Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн өрхийн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.	2021-2024	ХүХҮХ, ЖДҮДТ		Нийслэлийн төсөв	-	эрлэл эрхлэгчдийг	20-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.	-		Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-д 2023 онд өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой, ажлын байргүй 26 иргэнийг элсүүлж үнэ төлбөргүй ажлын байраар ханган дэмжлэг үзүүлэн ажилласан. Өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллага, сургалтын төвүүдтэй хамтран олон дадлага хосолсон 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 202 иргэнийг хамруулсан. Үүнд: - Хүлэмжийн суулгац бэлтгэх сургалтад 19; - Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл сургалтад 11; - Төсөл бичих аргачлал сургалтад 20; - Органик саван, лаа хийх сургалтад 50; - Оёмол, сүлжмэл хийх сургалтад 52; - Хүнсний ногоо нөөшлөх, хадгалах сургалтад 50 иргэн тус тус хамрагдсан. Мөн нийслэл, дүүргээс зохион байгуулсан 8 удаагийн үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд түрээсийн төлбөргүйгээр байршуулж, олон нийтэд сурталчлан танилцуулж 13 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжин ажилласан.	100%
Шаардагдах төсөв							758			216.2	20.0		

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.4. Дүүргийн төсөв, санхүү													
4.4.1 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ.	102	Орон нутгийн төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулсан эсэхэд хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангана.	2021-2024	СТСХ, ДАА	Нийт байгууллагууд	-	-	нийт 195 байгууллага шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ 87.6% байршуулсан.	Хуулийн хугацаанд 205 байгууллагын шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ 90% байршуулсан байна.	-	-	Хан-Уул дүргийн төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад 160 мэдээллээс 131, Засаг даргын Тамгын газар 160 мэдээллээс 110 мэдээллийг хуулийн хугацаанд тус тус https://shiledans.gov.mn/ сайтад байршуулсан. Үлдсэн мэдээллийг байршуулах хуулийн хугацаа болоогүй байна.	95%
4.4.2 Татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулна.	103	Цахим татвар төлөлт, төлбөрийн даалгавар үүсгэх үйлчилгээний талаар сургалт зохион байгуулж үйлчлүүлж байгаа татвар төлөгчийн тоог багасгах.	2021-2024	ТХ		Үйл ажиллагаа ны зардал Татварын хэлтэс	85	Төлбөрийн даалгавар үүсгэх цахим систем 100% цахим хэлбэрт шилжсэн боловч цахим хэрэглээний түвшин муу байна.	Цахимаар төлбөрийн даалгавар үүсгэх үйлчилгээг 70% д хүргэх.	21.3	-	Татварын алба нь 100 хувь цахим тайлангийн системийг ашиглан татварын үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хэрхэн авах, тайлан хэрхэн илгээх сургалтыг татвар төлөгч нарт тогтмол зохион байгуулж байна. Цахимаар татвар төлөлт өмнөх оны мөн үед 72 хувь байсан энэ онд 96 хувь буюу 374807 төлбөрийн даалгавраас 360082 буюу нь цахимаар төлөгдөж, 14725 буюу 4 хувь нь банк болон төрийн сангийн гүйлгээ байна.	100%
4.4.3 Дүүргийн орон нутгийн өмчийг бүртгэлжүүлэх, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	104	Дүүргийн төсвийн хөрөнгөөр бий болж буй хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.	2021-2024	СТСХ, ТЗУХ		-	-	Нийт 68 байгууллага хамрагдаж, тооллогын комисст ажлын тайлан ирүүлсэн.	Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа ажлуудад өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах, чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. 70 байгууллагад хөрөнгийн тооллого хийгдсэн байна.	-	-	Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/60, А/99 дүгээр тушаалаар хагас бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, тасаг, 25 хороо болон Засаг даргын дэргэдэх 5 хэлтэс, албадын 14 төрлийн өмч хөрөнгийг тоолж, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар зөвлөмж өгч, тооллогын дүн мэдээг нэгтгэн ашиглалтын хугацаа дууссан өмч хөрөнгийн бүртгэлийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 1,664,302,563 төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг актлах шийдвэрийг гаргуулахаар Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэн Засаг даргын Тамгын газрын даргын А/98 дугаар тушаалаар 112 нэр төрлийн 63,299,221 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг актласан. Иргэдэд үйлчлэх байруудыг данс бүртгэлд бүртгэн нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргэсэн. Дүүргийн Соёлын ордон, Цагдаагийн газарт шаардлагатай техник тоног төхөөрөмжүүд, “Зам засвар арчлалт” ОНӨААТҮГ-т авто зам будаг хайлуулж будах терма будгийн машин, “Хан-Эко тээвэр”, “Тохижилт үйлчилгээний төв”, “Эко хотын тээвэр”, “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ-т 1 трактор, 10 хог тээврийн автомашин, дүүргийн Татварын хэлтэст 4 нэр төрлийн тоног төхөөрөмж, 48 компьютер, “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т машин тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч, нийт 2,941,441,366 төгрөгийн өмчийг дээрх байгууллагуудын данс бүртгэлд бүртгүүлсэн. Дүүргийн 6 дугаар хорооны халуун усны барилгыг Нийслэлийн төсвийн нийт 433.432.529 төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлаж Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, Хүүхэд хамгаалах байраар ашиглаж байна. Мөн 16 дугаар хорооны Халуун усны барилгыг дүүргийн Цагдаагийн газрын камерын хяналтын төвөөр ашиглахаар засвар үйлчилгээ хийсэн.	100%
4.4.4 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	105	Дотоодын давуу эрх тооцох боломжтой төсөл арга хэмжээнд тухай бүрт тусгаж ажиллах	2020-2024	ХААА	Нийт байгууллагууд	-	-	Дотоодын давуу эрх тооцох төсөл арга хэмжээ 50%-тай байна.	Нийт арга хэмжээний 65%-д дотоодын давуу эрх тооцохоор тусгасан байна.	-	-	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дүгээр заалтын дагуу дотоодын үйлдвэрлэгчийг дэмжих зорилгоор 2023 онд хэрэгжүүлэх 107 төсөл арга хэмжээний 100 төсөл арга хэмжээнд дотоодын давуу эрх тооцохоор тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан. Тайлант хугацаанд дээрх 100 төсөл арга хэмжээнд оролцогчдын зүгээс холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаагүй тул давуу эрх тооцох боломжгүй болсон.	93%
Шаардагдах төсөв							85			21.3	-		

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.5. Гэр бүл													
4.5.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	106	Гэр бүл хүүхэд залуучуудад ээлтэй байгууллага, аж ахуйн нэгж, Шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	2021-2024	НХХ, ГБХЗХХ		Дүүргийн төсөв	16	"Хүүхэд гэр бүлд ээлтэй" 5 байгууллагыг шалгаруулсан.	5 байгууллага, 5 гэр бүлийг шалгаруулан сурталчилна.	4.0		Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг угтан "Онцлох гэр бүл" шалгаруулах удирдамж баталсан бөгөөд Хан-Уул дүүргийн хэмжээнд Онцлох 8 гэр бүлийг Оюунлаг гэр бүл, Спортлог гэр бүл төрлөөр шалгаруулан цахим мэдээллийн хэрэгслээр алдаршуулж, нийслэлийн онцлох гэр бүл шалгаруулалтад хүргүүлсэн. Мөн "Ээлтэй аж ахуй нэгж байгууллага", "Шилдэг эцэг эхийн зөвлөл" шалгаруулах удирдамжийн дагуу цэцэрлэг, сургууль, аж ахуйн нэгж байгууллага гэсэн 4 төрөлд материал хүргүүлсэн.	90%
	107	Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 250 өрхийг хөгжлийн үйлчилгээнд хамруулж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.	2021-2024	НХХ, ГБХЗХХ	Хороод	ГБХЗХХ-ийн төсөв	20	250 өрх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.	75 өрхийн амьжиргаа дээшилж, төслөөс хасагдсан байна.	5.0		Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018-2022 оныг хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн "Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т тус дүүргийн 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 250 өрхийг хамруулсан. Улаан загалмайн хороо, Гүүднэйборс ОУТББ хамтран 138 иргэнд "Гамшгийн үеийн анхны тусламж" сургалтыг зохион байгуулан анхны тусламжийн гарын авлага, тусламжийн иж бүрдэл олгосон. Мөн Гүүднэйборс ОУТББ-аас зорилтот бүлгийн өрхийн оюутнуудад "Тэтгэлэг хөтөлбөр"зарлаг 4, 5, 6, 8 дугаар хороодын 16 оюутанд 24.0 сая тэтгэлэг, 1991 өрхөд нийт 27.8 сая төгрөгийн ахуйн багц тус тус олгосон. Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжиж дууссан бөгөөд тус хөтөлбөрт хамрагдсан 250 өрхийн гишүүдийг түр болон байнгын ажлын байранд холбон зуучлах, хүнсний тусламж, хичээлийн хэрэгслийн дэмжлэг, гэр бүлийн төлөвлөгөө боловсруулах хөтөлбөр, амьдрах ухааны сургалт зэрэг хөгжлийн үйлчилгээнд үе шаттайгаар хамруулсан.	30%
	108	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийг ёслолтой бүртгэх	2021-2025	НХХ, СО, ГБХЗХХ	УБХ	Дүүргийн төсөв	18	2 иргэн хамрагдсан.	00 иргэн хамруулн.	5.0		Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслолын үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүндэтгэлийн танхимд 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, 25 залуу хос оролцсон ба "Хүүхэд, залуучууд, гэр бүл, хөгжил дэвшлийн төв"-ийн гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үнэ цэнэ, хосын харилцааны чиглэлээр гэр бүл, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдах эрхийн бичиг гардуулсан.	50%
4.5.2 "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн авьяас хөгжүүлэх сургалт, дугуйланг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудын чөлөөт цагт зориулсан танхим нээж соёлын үйлчилгээ үзүүлнэ.	109	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хөгжиж, сурч боловсрох таатай орчин бий болгох, үндэсний хэл соёл, уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	НХХ, БХ, ГБХЗХХ	ЕБС, СӨБ	Дүүргийн төсөв	170	-	Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна.	-	385.0	"Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 16 төсөл, арга хэмжээ, 2 дугаар зорилтын хүрээнд 6 төсөл, арга хэмжээ, 3 дугаар зорилтын хүрээнд 1 төсөл, нийт 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: - Хүүхэд бүрийг сурч хөгжихөд тэгш боломжоор хангах чиглэлээр "Богдон дахь соёлын өв" төсөл, 313, 326, 28, 134, 322, 324, 312, 134, 218, 290 дүгээр цэцэрлэгүүдэд гал тогоо, зөөлөн эдлэл нийлүүлж, хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэх 10 төсөл, ерөнхий боловсролын 163, 34, 52, 161, 165 дугаар сургуулиудад гал тогооны тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг нийлүүлэх 5 төсөл - Соёл урлаг, спортоор дамжуулан хүүхдийн бие бялдар, авьяасыг хөгжүүлэх чиглэлээр Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам" зохион байгуулах, Хүүхдийн спортын Зуны VII наадамд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх, Өсвөрийн шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, Азийн өсвөр үеийн сэрвээт сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх, "Өөрийгөө нээн хөгжүүлэх, сэтгэл зүйн үр чадвараа илэрхийлэх сургалт", Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот өрхийн хүүхдүүдэд бэлэг олгох зэрэг 6 төсөл, арга хэмжээ, - Бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр "Хүүхдийн эрдсийн шинжилгээ" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.	90%
4.5.3 Төр хувийн хэвшлийн түншлэлээр залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	110	Залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" байгуулж ашиглалтад оруулна.	2021-2024	ТГУХ, ТНБГХХ	ГЗБА	Нийслэл, дүүргийн төсөв	3,600	-	Эко зуслангийн барилгын ажлыг эхлүүлнэ.	1,000.0		Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт 402 амины орон сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сарсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламжтай залуу гэр бүл амрах зориулалт бүхий "Эко зуслан"-ийн загвар зураг, цахилгааны техникийн нөхцөл батлагдсан бөгөөд нийслэлийн Онцгой байдлын газартай зөвшилцөж байна.	30%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.5.4 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	111	Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулах	2021-2024	НХХ, ГБХЭХХ		Дүүргийн төсөв	28	500 залуу чуулга уулзалтад оролцсон.	500-аас доошгүй залуучуудыг чуулга уулзалтад оролцуулна.	7.0		"Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуусын бүтээлч хамтын оролцоо" уриан дор зохион байгуулагдах залуучуудын хөгжлийн үндэсний IX чуулганы салбар хэлэлцүүлгийг 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт 25 хорооны Залуучуудын хөгжлийн зөвлөлийн төлөөлөл, дүүргийн хөгжлийн зөвлөлийн төлөөлөл 35 залуу танхимаар оролцож, цахимаар 30 залуучууд санал хүсэлтээ ирүүлсэн. Хэлэлцүүлгийг "Залуучуудын хөгжлийн тэргүүлэх чиглэл", "Залуучуудын зөвлөлийн йл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал", "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд өгөх үнэлгээ", "Залуучуудын чиглэлээрх төрийн зарим чиглэлийг Иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх, тэдний оролцоо", "Залуучуудын үндэсний болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм, тогтолцоонд тусгах санал" гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж, нийт 25 саналыг үндэсний чуулганд хүргүүлсэн. 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний чуулганд Хан-Уул дүүргийн 20 залуу оролцсон.	30%
	112	Дүүргийн хөгжил, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд залуучууд идэвхтэй оролцох, хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэн, гэр бүлийн болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлж, эх оронч үзлийг төлөвшүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй хариуцалагатай иргэн болоход олон талт дэмжлэгийг үзүүлнэ.	2021-2024	НХХ, ГБХЭХХ, ЦШ	ХөХҮХ Хороод	Дүүргийн төсөв	50	-	Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна.	-	122.5 Залуучуудын хөгжил дэд хөтөлбөр	"Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 3 төсөл, арга хэмжээ, 2 дугаар зорилтын хүрээнд 1, 3 дугаар зорилтын хүрээнд 1 төсөл, 4 дүгээр зорилтын хүрээнд 12, нийт 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Төсвийн гүйцэтгэл 94 хувь. Үүнд: 1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих", "Ажилтай орлоготой залуус" өдөрлөг, Ажил, мэргэжилгүй боловч хөдөлмөрийн чадаартай 400 залуусыг солонгос хэл, компьютерийн анхан шат, үсчин, оёдол, эсгүүрийн мэргэжил олгох сургалтад хамруулах нийт 3 арга хэмжээ, 2. Залуу гэр бүл, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн "Тусч найзууд" төсөл, 3. Залуусыг эерэг хандлагад уриалах, эх орноороо бахархаж үзэл төлөвшүүлэх чиглэлээр "Залуучуудын уулзалт, хэлэлцүүлэг" төсөл, өсвөр үе, залуучууд амьдрах ухааны олон талт мэдлэгийг олгох "ЭРТЭЧ ЗАЛУУ" арга хэмжээг зохион байгуулж 13 удаагийн үйл ажиллагаанд 170 гаруй залуучууд хамрагдсан. 4. Залуучуудын урлаг, спортын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Залуучуудыг олон улсын болон дотоодын уралдаан тэмцээнд оролцуулахад нийт 12 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллав.	90%
4.5.5 Хараа хяналтгүй, Хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулж, хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.	113	Хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	2021-2024	НХХ, ГБХЭХХ, ЦГ	Хороод	ГБХЭХХ-ийн төсөв	4	4 удаагийн арга хэмжээгээр хараа хяналтгүй 54 хүүхдийг илрүүлж асран хамгаалагчид хүлээлгэн өгсөн.	4 удаагийн арга хэмжээ зохион байгуулна.	1.0	0.9	"Хүүхэд хамгаалал" 3 удаагийн арга хэмжээгээр 25 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 2 билльярд, баар, 12 рестораны, 6 зочид буудал, 18 траншей, 24 хүнсний дэлгүүр, 2 зах, худалдааны төв, 11 авто угаалга, 6 цахим тоглоомын газар, 1 хогийн цэг, 5 морины жүчээ, 4 арьс ширний үйлдвэр нийт 91 газарт хяналт тавьж, хөдөлмөр эрхлэгч-16, морь унаач-3, эцэг эхийн хараа хяналт сун-5, нийт 24 хүүхдийг илрүүлж, эцэг эх асран хамгаалагчдад хүлээлгэн өгсөн. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэдтэй холбоотой 8 гомдол, мэдээллийг шалгаж, баримтжуулан Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.20.7 дахь заалтын дагуу 8 торгуулийн арга хэмжээ авч, Цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн бүртгэлд 6 хүүхдийг бүртгэн хяналт тавьж байна. "Хүүхэд хамгаалал" 4 дэх удаагийн арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 04-14-ний өдрүүдэд дүүрэг дэх Цагдаагийн газартай хамтран зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөө батлуулсан. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Найз байя" нөлөөллийн аяныг 2023 оны 5-6 дугаар сард төрийн болон төрийн өмчийн бус 54 сургуульд зохион байгуулж, 15,000 гаруй сурагчдад мэдээлэл өгч, "Гэрэлт ирээдүйд Гар бүү хүр" уриатай 2 төрлийн постер бэлтгэн 25 хороо, 12 сургууль, 6 цэцэрлэгийн цахим хуудсаар 1263 хүнд түгээж, 16 байгууллагын эцэг эхийн зөвлөл, зорилтот бүлгийн 12 гэр бүлд хүүхэд хүмүүжлийн зөвлөгөө өгсөн.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.5.6 Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд архи, согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн "Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	114	"Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	ТЗУХ, ГБХЗХХ, ЦГ, ЭМТ	Хороод	Дүүргийн төсөв	43	-	Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна.	-	-	"Архигүй орчин" дэд хөтөлбөрийн 8 зорилт, 17 арга хэмжээний хэрэгжилт 85 хувьтай байна. Хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал: Электрон тамхины хор нөлөө", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Үе тэнгийн гадуурхалт", "Хүүхэд хамгаалал", "Цахим болон бусад орчинд өөрийгөө хамгаалах" "Архины хор уршиг" "Мансууруулах бодисын хор хөнөөл", "Архины хор хөнөөл" "Тамхинаас татгалзъя", "Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх нь", "Хорт зуршлаас урьдчилан сэргийлье" зэрэг 7 сэдвээр 9 удаагийн сургалтыг зохион байгуулж, 2 зөвлөмж, 1 шаардлага хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон, иргэд олон нийтэд сурталчлах чиглэлээр телевизэд 1, цахим сайтад 1, байгууллагын сайтад 15 мэдээлэл тус тус байршуулж, 11 төрлийн зурагт хуудас, постер бэлтгэн 58369 иргэнд хүргэсэн. "Архичид амилахуй" төрийн бус байгууллага, Цагдаагийн 1, 2-р хэлтэстэй хамтран "Эрүүлжүүлэх байр"-нд удаа дараа албадан эрүүлжүүлэгдсэн 215 иргэнд 9 удаагийн сургалт зохион байгуулан зөвлөмж өгч, "Гэртээ харих зам" хөтөлбөрийн хүрээнд 26, удаа дараа саатуулагдсан 108, нийт 134 иргэнийг нарийн мэргэжил /дотор, мэдрэл, гэмтэл, мөс засал, сүрьеэ, эмэгтэйчүүд, зурх судасны эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулж, гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 158 гэр бүлийн 308 иргэнд хамтарсан багаар дамжуулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн. Мөн нийслэлийн Эрүүл мэндийн газрын Аддиклогийн төв, ТВ-9 телевизийн мөрөөдөл биелдэг юм нэвтрүүлэгтэй хамтран "Та амьдарлаа өөрчилмөөр байна уу" зорилтод төсөлд 9 дүгээр хорооны 1 иргэнийг өөрийнх нь хүсэлтээр хамруулсан.	90%
	115	Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих аян зохион байгуулна.	2021-2024	НХХ, ГБХЗХХ, ЦГ, ЭМТ	Хороод	Дүүргийн төсөв	40	Давхардсан тоогоор хамтарсан багийн 687 гишүүн хамрагдсан.	4-с доошгүй сургалт зохион байгуулсан байна.	10.0	Давхардсан тоогоор хамтарсан багийн 227 албан хаагчид "ХТУ-108-ын дуудлагад хариу өгч, мэдээллийн дагуу ажиллах арга зүй" болон үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхжуулах, 3 удаагийн сургалт зохион байгуулж, 25 хорооны хамтарсан багийн үйл ажиллагаанд 1 удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлснээр хамтарсан багийн үйл ажиллагаа идэвхжиж, хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээллийн шийдвэрлэлт 42 хувиас 68 хувь болж өссөн. Мөн хамтарсан багаас Эрүүл мэндийн төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 158 гэр бүлийн 308 иргэн, 26 өсвөр насны хүүхдэд сэтгэцийн эмч үзлэгт хамруулж, сэтгэл зүйчийн зөвлөгөө өгсөн. Нийслэлийн цагдаагийн газрын гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагад бүргэгдсэн 45 өрхөд 2 удаа нөхцөл байдлын үнэлгээ хийж, эргэн хяналт тавьж байна.	100%	
4.5.7 Тусгай хэрэгцээт иргэд, ахмад настан болон залуу ээжүүд зэрэг нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн сайн дурын олон талт дэмжлэг үзүүлэх "Тусч найзууд" бүлгэмийг хороо бүрт ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	116	"Тусч найзууд" бүлгэмийг хороо бүрт ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	2021-2024	НХХ, ГБХЗХХ	Хороод	ГБХЗХХ-ийн төсөв	20	-	5-аас доошгүй бүлгэм байгуулагдсан байна.	5.0	Хан-Уул дүүргийн нисэх, яармагийн бүсийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16, 21, 25 дугаар хорооны гэртээ хүүхдээ харж байгаа 20-45 насны ээжүүд, эмэгтэйчүүдийн нийгмийн амьдралд оролцох идэвхийг нэмэгдүүлэх, харилцан бие биенээсээ суралцах, дэмжих, хорооны нутаг дэвсгэрт сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор "Тусч найзууд" бүлгэмийг байгуулж, хүнсний ногоо нөөшлөх технологийн талаар онол, дадлага хосолсон сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, нийт 200 эмэгтэйг хамруулсан. Шинээр байгуулагдсан "Тусч найзууд" бүлгэмийн эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх, хөгжил оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус дүүргийн 12, 209, 290, 312 дугаар цэцэрлэгийн 2-5 насны хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нарт "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сургалтыг зохион байгуулсан.	70%	

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.5.8 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулж, шаттайгаар хэрэгжүүлнэ.	117	Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, боломж баталгааг хангаж, жөндөрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадурхалтаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	НХХ, ГБХЗХХ	ХөХҮХ Хороод	Дүүргийн төсөв	70	Үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан.	Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна.	20.0	6.3	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөр 4 зорилт, 10 арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 160 албан хаагчийн хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг 2 маягтын дагуу гаргаж программд оруулсан бөгөөд судалгаагаар хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан. 2. Жендэрийн Үндэсний хороо болон бусад байгууллагаас зохион байгуулсан 4 сургалт, форум, хэлэлцүүлэгт Засаг даргын Тамгын газрын 2 удирдах ажилтан, 7 мэргэжилтэн, ТББ-ын 1 мэргэжилтэн, 25 хорооны 100 гаруй эмэгтэйг тус тус хамруулсан. 3. Мөн "Өлзийт асар" ТББ-ын нийгмийн ажилтныг Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад хамруулсан. 4. Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх "Харилцан хүндэтгэе" сарын аяныг 2023 оны 03 дугаар сард зохион байгуулж, 2 удаагийн нөлөөллийн арга хэмжээнд 3600 гаруй иргэн, 7 сургалтад нийт 673 иргэн, "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг 11 дүгээр сард зохион байгуулж, дүүргийн Охидын зөвлөл болон хөвгүүдийн зөвлөлийн уулзалт хэлэлцүүлэгт 42 сурагч, "Жендэр ба хөгжил" сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 53 сурагч, их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн оюутан сурагчдын дунд "БЗДХ-ДОХ-өвчнөөс сэргийлэх" сургалт, хэлэлцүүлэг, эрүүл мэндийн үзлэг зохион байгуулж нийт 8 сургуулийн 1520 оюутан, сурагчийг хамруулсан. 6. МСҮТ, коллежийн оюутан сурагчдын дунд зохион байгуулсан "Жендэрийн талаарх ойлголт, харилцаа хандлага" илтгэлийн уралдаанд 50, Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох үе тэнгийн сургагч багшийн сургалтад МСҮТ, Коллеж, ЕБС-ийн нийт 30 оюутан сурагчийг хамруулж, бэлтгэсэн. 7. Эрүүл мэндийн төв мэс заслын 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтанд хамруулан Нэгдсэн эмнэлгийн яармаг амбулаторт эргэжүүлэгчдийн кабинетыг шинээр байгуулж, орон нутгийн төсвөөс 22.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.	90%
Шаардагдах төсөв							4,079			1,057.0	514.7		
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ							86,470			19,568.5	24,782.4		87%
ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ													
5.1 Газрын харилцаа													
5.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системтэй холбож, хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.	118	Хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2024	ГЗБА, УБХ	ТНААХ Хороод	-	-	Дүүргүүдэд дэд ажлын хэсэг байгуулагдсан.	Иргэн, хуулийн этгээдийн хаягийг шинэчлэх ажлыг зохион байгуулах 70 хувь.	-	-	Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд бүрэн нэвтрээгүйгээс иргэдийн газарт хаяг олгоход үүсч байгаа асуудлыг нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01-12/1918 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу байшин барилга бүртгэхдээ иргэдэд хүндрэл учруулахгүй давхар хаяг олгож байна. Хаягийн нэгдсэн системийг бүрэн ажиллуулахаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 10 гэрээт ажилтныг уртасгасан цагаар ажиллуулж, нийслэлийн 8 дүүргийн хаягийн зургийг хийж дуусгасан.	80%
	119	Дүүргийн нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг эзэнжүүлэх	2021-2024	ГЗБА		-	-	нийт 102 ширхэг цэг тэмдэгт байдаг хамгаалалтыг хариуцах эзэнгүй.	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт хамгаалалтыг эзэнжүүлж гэрээ байгуулна 70 хувь.	-	-	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01-12/862 албан бичгээр "Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийх" ажлын даалгавар батлагдсаны дараа зохион байгуулж ажиллах чиглэл ирсэн бөгөөд ажлын даалгавар батлагдаагүй хүлээгдэж байна.	30%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.1.2 “Орц-Гарц” арга хэмжээг хэрэгжүүлж, гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг шийдвэрлэж түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ.	120	Дүүргийн хэмжээний Гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн судалгаа гаргаж, зөрчлийг арилгуулах "Орц-гарц" арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ГЗБА, ТНААХ	Хороод	Улс, нийслэл, дүүргийн төсөв	-	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/513 дугаар захирамжийн хүрээнд 27 байршилаас 20 байршлыг бүрэн чөлөөлж, ажлын явц 93.2 хувьтай.	Зөрчлийн тоо бууруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.	-	Дүүргийн нутаг дэвсгэр дэх зөрчлийн судалгааг шинэчлэн гаргаж 2023 онд бүртгэгдсэн нийт 291 зөрчлөөс 257 зөрчлийг холбогдох шийдвэрийн дагуу арилгуулж ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/321 дүгээр захирамжаар Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 155 гарааш чөлөөлөхөөр тусгагдсанаас 120 гарааш, төлөвлөгөөнд тусгагдаагүй 8 гараашийг бүрэн чөлөөлсөн. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн "Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/394 дүгээр захирамжаар 2023 онд Хан-Уул дүүрэгт 23 байршилд 1921 м хашаа хайсыг бүрэн чөлөөлсөн. НЗД А/858, ДЗД А/31 дугаар захирамжуудийн хүрээнд 32 байршилд 3137 м урт хашааг тус тус чөлөөлсөн. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн "Хууль, нор, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/242 дугаар захирамж, Дүүргийн Засаг даргын 2023 оны А/545 дугаар захирамжийн хүрээнд Наадамчдын зам дагуу 45, Чингисийн өргөн чөлөө гудамж 16, Зайсангийн зам дагуу 23, Түргэн хоолны 18 цэг нийт 102 ТҮЦ нүүлгэн шилжүүлсэн.	90%	
5.1.3 Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	121	Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх	2021-2024	ГЗБА	Хороод	-	-	НЗД-ын захирамжаар 12 иргэн, аж ахуйн нэгж, ДЗД-ын захирамжаар 49 иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож шийдвэрлэсэн.	Хуулийн хэрэгжилтийг хангах, газар ашиглалт сайжрах.	-	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг үндэслэн дүүргийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар 21 иргэний 23 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон. Үндны усны хориглолтын бүсэд олгогдсон 29 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг дүүргийн Засаг даргын 2023 оны А/507 дугаар захирамжаар хүчингүй болгосон. 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул гол дагуу үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлгүй бууж үерт өртсөн айл, өрхийн иргэдийн эрүүл мэнд, амь нас эд хөрөнгийг гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Хан-Уул дүүргийн засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/428 дугаар захирамжаар 28 айл өрхийг 10 дугаар хорооны нутаг дэвсгэрлүү нүүлгэн шилжүүлсэн, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт төсөл хэрэгжүүлж буй "Фжи девелопмент" ХХК зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй барилгын ажил эхлүүлсэн таслан зогсоох арга хэмжээг авч нүхийг булж, хашааг татуулсан. 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт 130 дугаар сургууль, 218 дугаар цэцэрлэгийн зүүн талаар авто болон явган зам гаргах ажилд нийслэлийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Явган хүний замын хөдөлгөөнд саад учруулж байршуулсан ТҮЦ, зөөврийн байгууламжуудийн нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч Яармагийн зам дагуу ТҮЦ-гүй болсон.	90%	
5.1.4 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	122	Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх	2021-2024	ТНААХ, ГЗБА	Хороод	-	-	НЗД-ын 2020 оны А/715 дугаар захирамж гарсан.	Гарсан зөрчлийн 50-аас доошгүй хувьд стандарт хангуулж ажиллана.	4.5	Дүүргийн нутаг дэвсгэрт 2023 онд эрүүл мэнд, хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, барилга байгууламж, хот нийтийн аж ахуй, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагын 18 улсын байцаагч 357 төлөвлөгөөт, 943 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 2297 зөрчил илрүүлэн 5 зөвлөмж, 146 шаардлага, 49 албан даалгавар, 197 дүгнэлт, 2 акт хүргүүлж, 240 өргөдөл гомдол хүлээн авч, 606 албан бичиг шийдвэрлэн 52 ААНБ, 8 иргэнд 86,1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, стандартыг мөрдүүлж байна. Тухайлбал; 78 мэдээллийн тулгуурт самбар, 43 ширхэг А самбар, 555 хулдаасан самбар буулгаж, нийт 1775 иргэн, ахуйн нэгжид хаягийн байгууламжийг стандартыг хэрэгжүүлэх мэдэгдэл өгч, 128 авто машины гарааш хүрүүлж, 61 түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн захирамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, барилгын суурь ухсан байгаа байршлын судалгаа Архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээтэй 27 барилга, 11, 22 дугаар хороодод байрлах Архитектур төлөвлөлтийн даалгаваргүй, барилгын ажлын зөвшөөрөлгүй, барилгын суурийн нүх ухсан 3 байршилд зөрчил арилгуулах, аюулгүй байдлыг хангуулсан.	100%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	123	Стандартын шаардлага хангасан гэрэлтүүлгийг шаардлагатай байршуулахад байршуулна.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Дүүргийн төсөв	1,500	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан.	Стандартын шаардлага хангасан 100 ширхэг гэрэлтүүлгийг байрлуулсан байна.	200.0	1000.0 ДОНХС	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Солонгос улсын "Дасан лайтинг" ХХК, дүүргийн нутаг дэвсгэрийн гэрэлтүүлэг хариуцсан "Новелнэтворж" ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гурван талт санамж бичгийн хүрээнд хуучин, тусгал муутай 3000 ширхэг гэрэлтүүлгийн толгойг 50 Вт лед гэрлээр солих хөрөнгө оруулалтын төсөл Бүгд Найрамдах Солонгос Улсын Аж үйлдвэрийн яамны эхний шалгаруулалтад тэнцсэн, 2 дахь шатанд хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Эрчим хүчний яамнаас дэмжлэг хүссэн албан бичиг боловсруулагдаж байна. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн авто замын байгууламжийн ажлын хүрээнд 76, Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 4, 5, 7, 8, 20 дугаар хороонд 138 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулсан. Мөн дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 1.59 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 526 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах 3 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийг засварлах ажлын хүрээнд 2023 онд 3975 метр кабель шугам, 712 ширхэг гэрэл, 641 ширхэг 50 вт прожуктор, 163 ширхэг пускатель, 380 ширхэг 50 вт лед трансформатор, 68 ширхэг 70 вт лед трансформатор, 252 ширхэг гал хамгаалагч, 210 ширхэг цахилгааны самбарын хайрцгийг засварлаж, 95 ширхэг гэрэлтүүлгийн шонг сольж, Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 137, Наадамчдын зам дагуу 171 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, ил гарсан 17461 метр кабелийг цэгцэлж булж, Дунд голын гудамж дагуу 40 гэрэлтүүлгийн шонг шилжүүлж, орчны аюулгүй байдлыг хангасан, гэрэлтүүлгийн асалт 99.1 хувьтай байна.	
5.1.5 Биокомбинат, Туул, Өлзийт хороодод нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн боловсруулж, бүс нутгийн газар ашиглалтыг сайжруулна.	124	Эзэмшлийн газраа 2-оос дээш жил ашиглаагүй иргэд хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгуулж, дахин олголт хийх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	2022-2024	ТГУХ, ГЗБА	ТНААХ, Хороод	Дүүргийн төсөв	-	-	Бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн газар ашиглалт сайжруулах дахин төлөвлөлт хийх.	-	-	-	0%
5.1.6 Туул тосгон Биокомбинат орчмын хайрганы карьериаас үүдэлтэй газрын эвдрэл доройтлын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөн сэргээлт хийнэ.	125	Түгээмэл тархацтай ашигт малын олборлолтын улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх ажлын эдийн засгийн тооцоо, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.	2021-2024	ТНААХ		Дүүргийн төсөв	195	310,6 га газар уул уурхайн олборлолтын нөлөөгөөр эвдэрсэн байна.	Нөхөн сэргээх шаардлагатай газрын хэмжээг тодорхойлон, нөхөн сэргээх ажлын техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан нөхөн сэргээлт хийнэ.	50.0		Хан-Уул дүүрэгт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй 37 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 17 аж ахуйн нэгж, байгууллага олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын нөлөөгөөр эвдэрсэн газарт 2022 онд ажлын хэсэг гарган 4 удаа хяналт шалгалтыг хийж, 124.43 га эвдрэлтэй талбайг тогтоосон. Нийгмийн хариуцлагын хүрээнд "Үйлсийн алтан хэлхээ" ТББ-тай хамтарч дүүргийн 13 дугаар хорооны нутагт хайрга дайрга олборлолтын улмаас эвдэрсэн 1 га талбайд техникийн болон биологийн жишиг нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлэхээр, талбайд хуримтлагдсан хог хаядлыг цэвэрлэж, техникийн нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн. Биологийн нөхөн сэргээлтийг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөөний дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуйн нэгж байгууллага 12.6 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 5.4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)			
5.1.6 Туул тосгон Биокмбинат орчмын хайрганы карьерис үүдэлтэй газрын эвдрэл доройтлын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөн сэргээлт хийнэ.	126	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	2021-2024	ТНААХ, ЦГ		Дүүргийн төсөв	120	"Нөхөн сэргээлт 2020" аяны хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 91 аж ахуйн нэгж байгууллагын талбайд хяналт шалгалт явуулсан.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлыг тогтмол зохион байгуулна.	30.0	50.9	Дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуйн нэгж, байгууллагад батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 20-ны хооронд хяналт, шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч, давхардсан тоогоор 11123 тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил гаргасан 9834 тээврийн хэрэгслийн жолоочид 206,125,000 төгрөгийн торгууль ноогдуулж, зөрчил арилгах арга хэмжээ авсан. Мөн 6 аж ахуйн нэгж, байгууллага 2023 оны уулын ажлын болон менежментийн төлөвлөгөөгөө Нийслэлийн байгаль орчны газраар батлуулж зөрчлөө арилгасан. Төв аймгийн Алтанбулаг суманд болон Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 26 байгууллагын 536 тээврийн хэрэгсэл хариуцагчтай "Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ" байгуулан дүүргийн нутаг дэвсгэрт 3 пост хяналт тавьж байна. "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт" төсөл арга хэмжээний хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодод шилэн кабель татах, 10 ширхэг тусгай зориулалтын камер суурилуулах, ажил хийгдэж ажлын явц 95 хувьтай хэрэгжиж байна. Тус хяналтын цэгүүдийг камерын хяналтын төвд холбох ажил хүлээгдэж байна.	100%	
Шаардагдах төсөв							1,815			280.0	1,055.4			
5.2 Орон сууц														
5.2.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг иргэд оршин суугчдын харилцан ойлголцлын үндсэн дээр талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	127	Нисэх, Яармагийн гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй, нам давхрын болон амины сууцны хороолол болгох ажлыг тууштай хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ	Хороод	Улс, нийслэл төсөв	-	Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 48 дугаар тогтоолоор 4-8 дугаар хороодын 168 га газрыг дахин төлөвлөн барилгажуулахаар баталсан.	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.	-	-	-	Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 314.75 га талбай буюу 5781 нэгж талбарт 9 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. Жилийн эцсийн байдлаар 464 нэгж талбар чөлөөлж, 4 блок 480 айлын орон сууц ашиглалтад оруулж, 152 нэгж талбартай гурвалсан гэрээ байгуулаад байна. Нийслэлийн Орон сууц бодлогын газартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 09, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тус тус дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны 600 гаруй оршин суугч иргэдийг хамруулан гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн явцын талаарх мэдээлэл өгөх, санал хүсэлтийг сонсох, хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. Мөн дүүргийн Засаг дарга Нийслэлийн орон сууц бодлогын газартай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 26, 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд яармагийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд эрх нь хөндөгдөж буй иргэдийн төлөөлөлтэй санал сонсох уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, тулгарч буй асуудал болон санал хүсэлтийг холбогдох газарт уламжилсан. Түүнчлэн "Иргэдээ сонсье" хөтөлбөрийн хүрээнд яармагийн 4-8 дугаар хорооны давтагдсан тоогоор 360 ирснээс 25% нь дахин төлөвлөлтийг шуурхай хэрэгжүүлэх, 52% нь дэд бүтэцэд холбогдож хашаандаа сайхан амьдрах санал гаргасан байна.	70%
5.2.2 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлыг үргэлжлүүлнэ.	128	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны хэрэгжиж буй төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран үргэлжлүүлнэ.	2021-2024	ТГУХ		Улс, нийслэл төсөв	-	7 гагц арга хэмжээ явагдаж байна.	Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны эрчимжүүлнэ.	-	-	-	Дүүргийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 35 орон сууцны барилга байгаагаас 31 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, 4 барилгад сонгон шалгаруулалт зарлагдах шатанд байна. Төсөл хэрэгжүүлэгчид нийт 2339 айлын 12 орон сууц ашиглалтад оруулж, 816 өрхийг шинэ орон сууцаар хангасан байна. "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах" төслийн явцын талаарх мэдээллийг сар бүр шинэчилж, Хот байгуулалт хөгжлийн газартай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 10, 05 дугаар сарын 09-ний өдөр тус тус "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах" ажлын явцын талаарх мэдээлэл өгөх, санал солилцох уулзалт хэлэлцүүлгийг 1, 2, 3 дугаар хорооны 500 гаруй оршин суугч иргэдийг оролцуулан зохион байгуулсан. "Иргэдээ сонсье" хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар хорооны Нэхмэл 7, 11 дүгээр байр, 3 дугаар хорооны Элит 073 дугаар байр, 20 дугаар хорооны Дэвшил 36 дугаар байрны нийт 209 иргэнд АШХНЗОС-ны дахин төлөвлөлтийн явцын талаарх мэдээ, мэдээллийг хүргэн эрх нь хөндөгдөж байгаа иргэдийн санал хүсэлтийг сонсон холбогдох байгууллагад уламжлах ажлыг зохион байгуулаад байна.	70%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.2.3 Нийтийн зориулалттай орон дулаалах, ажлыг хэрэгжүүлж, сууцны сууцнуудыг засварлах үе оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	129	Нийтийн зориулалттай хуучин орон сууцны засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	667	-	4-өөс доошгүй байрны дээвэр, фасадын ажил хийгдсэн байна.	-	1797.6 ДТХО	Дүүргийн хэмжээнд нийт 7 байрны фасад засварын ажил бүрэн дуусаж, 5 байрны фасад засварын ажлын явц 50 хувь, 3 байрны фасад засвар, 12 байрны дээвэр засварын ажлын гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна. Төсөл, арга хэмжээг явцаар нь авч үзвэл: • Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /2, 3 дугаар хороо/ төсөл арга хэмжээний хүрээнд 2 дугаар хороо 9 дүгээр байр, 3 дугаар хороо 1а байрны фасад засварын ажил хийгдэж 84 өрхийн ая тухтай, дулааны алдагдалгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн. • Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /12, 13 дугаар хороо/ төсөл арга хэмжээний хүрээнд 12 дугаар хорооны 38, 53 дугаар байр, 13 дугаар хорооны 2, 5, 6 дугаар байрны фасад засварын ажил хийгдэж 176 өрхийн ая тухтай, дулааны алдагдалгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн. • Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /Нисэхийн бүс/ төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжих, 10 дугаар хорооны 1, 7, 62, 63, 64 дүгээр байрны фасад засварын ажлын явц 50 хувь, 2024 оны 5 дугаар сард бүрэн хэрэгжиж дуусна. • Нийтийн зориулалттай орон сууцны засвар төсөл арга хэмжээ гүйцэтгэгч шалгаруулах шатанд байна Энэхүү төсөл, арга хэмжээний хүрээнд 10 дугаар хорооны 61/1, 61/2 байр, 12 дугаар хорооны 52 дугаар байрны фасад засварын ажил, 19 дүгээр хорооны 27/1, 86, 88, 96 дугаар байр, 25 дугаар хорооны 703, 706, 714, 715, 719, 722, 725, 727 дугаар байрны дээвэр засварын ажил хийгдэнэ.	100%
5.2.4 Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох газартай хамтран зохион байгуулж, хэвийн найдвартай ажиллагааг хангана.	130	Шаардлагатай байршлуудад гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг ажлыг үргэлжлүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	45	-	2 байршилд гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажил хийнэ.	124.0	66.1 ДТХО 310.6 Өвөлжилтийн бэлтгэл зардал	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ дүүргийн 13, 14 дүгээр хорооны халаалтын зуухны хуучирч муудсан дулааны шугамыг хэсэгчлэн шинэчилж, солих шугам хоолойн угсралтын ажил бүрэн дууссан. Гадна шугам сүлжээний шинэчлэлийн ажилтай уялдуулан өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн төсвийн 159.4 сая төгрөгийн хөрөнгөөр 13 дугаар хорооны 1, 2, 3, 4, 5 дугаар байрны барилгын доторх ашиглалтын шаардлага хангахгүй шугам хоолой, халаах хэрэгсэл, тоноглолуудыг засварлаж, шинэчилсэн. Мөн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 41, 71 дүгээр цэцэрлэг, 34, 52, 114 дүгээр сургууль, 11 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төв, 6, 9 дүгээр хорооны байр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн цэвэр ус, дулаан, ариутгах татуургын шугам сүлжээ, халаах хэрэгсэлүүдийг засварлаж, шинэчилсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 6 дугаар хороонд байрлах хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн 2 давхар барилгын дотор сантехник, дулааны ажлыг гүйцэтгэж, Цэвэр агаар төслийн хүрээнд цэвэр, ус дулааны төвлөрсөн шугамд холбосон.	100%
Шаардагдах төсөв							712			124.0	2,175.0		
5.3 Дэд бүтэц													
5.3.1. Дүүргийн авто замын ачааллыг бууруулах чиглэлээр шинээр авто зам барьж, хороолол доторх авто замд засвар, шинэчлэлт хийнэ.	131	Засварлах, өргөтгөх, шинээр тавих шаардлагатай замын судалгааг гарган авто замын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ, ХУЗЗА ОНӨААТҮГ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Улс, нийслэл, дүүрэг төсөв	16,960	Дүүргийн 5, 16, 21-р хороонд 3.1 км авто зам тавих ажлын гэрээ байгуулагдан, шинээр 2 км-ээс доошгүй авто зам тавина.	Зам өргөтгөх, нөхөс хийх зэрэг засвар үйлчилгээ хийгдэж, шаардлагатай байршилд шинээр 2 км-ээс доошгүй авто зам тавина.	4,000.0		Гадаадын зээл тусламж, улс, нийслэл, дүүргийн төсөв, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр дүүргийн 3, 8, 9, 11, 12, 15, 16, 17, 19, 20, 21, 23, 25 хорооны 21 байршилд 17.08 км хатуу хучилттай авто зам, засвар, шинэчлэлтийн ажил хэрэгжиж байгаа бөгөөд 8.64 км авто замын ажил дуусаж, 8.44 км авто замын ажил гүйцэтгэлийн шатанд хэрэгжиж байна. Үүнд: 11-р хороо, Зайсан тойруу, 0.81 км авто замын хэсэгчилсэн шинэчлэлтийн ажил, Рома хотхоны зүүн талд Тэнгэр рашааны гудамжийг гудамжтай холбох 0.18 км туслах замын ажил, "Их тэнгэр цогцолбор"-ын баруун шалган нэвтрүүлэх цэгээс тусгай объект хүртэлх 0.43 км авто замын ажил, 16, 25-р хороо, Нисэхийн эцсийн автобусны буудлаас Сонсголонгийн төв зам хүртэлх 2.2 км авто зам, 17, 18-р хороо, Маршал таун хотхоноос Гэрлүг хотхон хүртэлх 0.3 км авто зам, 19-р хороо, Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох нийт 0.64 км авто замаас 0.4 км авто замын ажил, 19-р хороо, 27 дугаар цэцэрлэгийн хойд уулзвараас Монгол нэхмэл ХХК хүртэл 0.07 км авто зам, 19-р	100%
5.3.1. Дүүргийн авто замын ачааллыг бууруулах чиглэлээр шинээр авто зам барьж, хороолол доторх авто замд засвар, шинэчлэлт хийнэ.	131	Засварлах, өргөтгөх, шинээр тавих шаардлагатай замын судалгааг гарган авто замын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ, ХУЗЗА ОНӨААТҮГ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Улс, нийслэл, дүүрэг төсөв	16,960	Дүүргийн 5, 16, 21-р хороонд 3.1 км авто зам тавих ажлын гэрээ байгуулагдан, шинээр 2 км-ээс доошгүй авто зам тавина.	Зам өргөтгөх, нөхөс хийх зэрэг засвар үйлчилгээ хийгдэж, шаардлагатай байршилд шинээр 2 км-ээс доошгүй авто зам тавина.			хороо, Богд Жавзандамбын гудамжны 0.47 км авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлтийн ажил, 21-р хороо, "Буянт-Ухаа спортын ордон"-ын баруун хойд талд 0.5 км авто зам, 23-р хороо, Наадамчдын замаас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл 4 эгнээ 0.7 км авто замын ажил тус тус ашиглалтад орсон. 10, 12-р хорооны авто замын ажил цахилгааны шугам сүлжээ чөлөөлөх гүйцэтгэгч шалгаруулах шатанд, 23-р хороо, Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн 1.53 км авто замын шинэчлэлтийн ажлын явц 20 хувийн гүйцэтгэлтэй. 8-р хороо, Чингисийн хүрээгийн авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх 1.6 км авто зам, 20-р хороо, Мишээл экспогийн баруун талын орон сууц хороолол доторх 0.41 км авто замын ажлууд худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. 9, 14, 16, 25-р хорооны гэр хорооллын гудамжинд тавих хатуу хучилттай авто зам ажлын зураг төсөв боловсруулагдах шатанд , 1, 2, 8, 9, 12, 15, 16, 17, 19, 20-р хорооны 10 байршилд шинээр авто зам тавих болон засварлаж шинэчлэх зураг төсөл боловсруулах 7 төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч шалгаруулах шатанд тус тус хэрэгжиж байна.	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)			
5.3.2 Төмөр бетон гүүрийн байгууламжийг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, шинэчлэх ажил хэрэгжүүлнэ.	132	Шинээр төмөр бетон гүүрийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	2021-2024	ТГУХ		Улс, нийслэл төсөв	353	-	Төмөр бетон гүүрийн байгууламжийн ажлыг холбогдох байгууллагатай хамтран эхлүүлнэ.	-		Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар төмөр бетон гүүрийн байгууламжийн 5 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд: 1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, замын барилга (1 дүгээр хэсэг гүүрийн барилгын ажил 483 метр)"-ын ажлын гүйцэтгэгчээр "Мото сервис" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Гүүрийн байгууламжийн суурь цугалтын ажил хийгдэж байна. Тус гүүрийн ажлын явц 80 хувьтай хэрэгжиж байна. 2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 11 дүгээр хороо "Зайсангийн төмөрбетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлт /225 метр-ийн ажил"-ын гүйцэтгэгчээр "ЗМЗ" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Шинэ гүүрийн барилга угсралтын ажил бүрэн дуусаж, зорчих хөдөлгөөнийг нээсэн. 3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хороонд хэрэгжиж буй "Дунд голын 60 метр урт, 2 эгнээ гүүрийн барилгын ажил"-ын барилга угсралтын ажил бүрэн дуусаж, ашиглалтад орсон. 4. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3 дугаар хороонд хэрэгжиж буй Баруун үйлдвэрийн гудамжны 42 метр урт, 4 эгнээ төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил дуусаж, зорчих хөдөлгөөнийг нээхээр бэлтгэл ажлыг хангуулж байна. 5. Дүүргийн 12 дугаар хорооны Цагаан эргийн модон гүүрийг төмөр бетон гүүр болгон шинэчлэх ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр "Эм Ай Эйл" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Гүүрийн ажлын зураг төсөл боловсруулагдаж байна.		100%
5.3.3 Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан явган зорчигчийн гүүрэн болон нүхэн гарцыг авто зам дээгүүр барих ажлыг хэрэгжүүлнэ.	133	Наадамчдын авто зам дагуу 1-ээс доошгүй байршилд нүхэн болон гүүрэн гарц байгуулна.	2021-2024	ТГУХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	2,000	-	Наадамчдын авто зам дагуу шаардлагатай 1 байршилд нүхэн гарцын ажил эхлүүлнэ.	-		Дүүргийн төсвийн хөрөнгөөрд он дамжин хэрэгжиж буй 24 дүгээр хороо, Хүннү молл худалдааны төвийн урд "Наадамчдын авто замд 50.7 метр урт, 5.8 метр өргөнтэй явган хүний нүхэн гарц"-ны зорчих хэсгийн ханыг металл хавтангаар бүрж, дотор заслын ажил дуусган нэмэлтээр хяналтын 6 ширхэг камер суурилуулж, ашиглалтад оруулсан.		100%
5.3.4 Сургууль, цэцэрлэгийн гадна талбай болон орон сууцны хотхон доторх шороон хөрс бүхий талбайд авто зогсоолуудыг барьж, байгуулна.	134	Сургууль, цэцэрлэг болон орон сууцны гадна талбайн авто зогсоолыг шинэчлэн сайжруулна.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	740	-	2-оос доошгүй байршилд авто машины зогсоол байгуулсан байна.	200.0	НТХО ДТХО Зарцуулсан хөрөнө бичих	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны 39 дүгээр байрны ард 500 м.кв талбайд 15 авто машины зогсоол, 11 дүгээр хорооны "Ар зайсангийн гудамжнаас дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил"-ын хүрээнд дугуй цагааны тохижилтын ажлын хүрээнд 1200 м.кв талбайд 36 авто зогсоолыг шинэчилж, ашиглалтад оруулсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 3 дугаар хороонд он дамжин хэрэгжсэн 4 дүгээр клиник сувиллын гадна талбайн тохижилтын ажлын хүрээнд 265 м.кв талбайд 10 авто машины зогсоол зогсоол, зам, 9 дүгээр хороо 134 дүгээр цэцэрлэгийн орчмын 694 м.кв талбайд орц, гарц бүхий авто зам, 11 авто машины зогсоол, 10 дугаар хорооны 60/2 дугаар байрны гадна 740.8 м.кв талбайд эко хавтан хучилттай 27 авто машины зогсоол, 61/2 байрны зүүн талд авто зам дагуу 313 м.кв талбайд асфальт бетонон хучилттай 9 авто машины зогсоолууд тус тус ашиглалтад орсон. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны 120 мянгат 20, 21 дүгээр байр орчмын зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын тендер 2 удаа зарлагдсан. Тендер дахин зарлагдах шатанд, 1, 2, 8, 10, 13, 20, 22 дугаар хорооны 9 байршилд авто зам, зогсоолын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч шалгаруулах шатанд тус тус хэрэгжиж байна. 2023 онд нийт 3712.8 м2 талбайд 108 авто машины зогсоол шинээр ашиглалтад орсон.		100%
5.3.5. Сул шороон хөрсийг зулэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	135	Сул шороон хөрс бүхий талбайг хатуу хучилттай болгон, тохижилтын ажлыг хийж, гүйцэтгэнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ	Хороод	Улс, нийслэл, дүүрэг төсөв	400	15,653 м2 талбайг зулэгжүүлж, 48,035 м2 талбайг цардмалжуулж хатуу, хучилттай болгосон.	15,000 м2 -аас багагүй сул шороон хөрс бүхий талбайг зулэгжүүлнэ.	100.0	551.8 ДТХО	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 3, 5, 7, 12, 14, 20 дугаар хорооны 7 байршилд 2199,8 м.кв, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээт 8 байгууллага нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын ажлын хүрээнд 13930 м.кв, хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 1, 2, 5, 11, 12, 13, 16, 21, 22, 24, 25 дугаар хорооны 36 аж ахуйн нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо 8063 м.кв, нийт сул шороон хөрс бүхий 24192.8 м.кв талбайг зулэгжүүлсэн байна.		100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.3.6 Стандарт нийцсэн дугуйн болон явган хүний замыг шинээр барьж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	136	Явган хүний замыг стандартад нийцүүлэн шинэчлэх болон шинээр явган хүн, дугуйн зам байгуулах замаар иргэдийн явган болон дугуйгаар зорчих хэсгийг сайжруулж, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авна.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	1,200	2020 онд 2.5 км явган хүний зам, 1.6 км дугуйн зам ашиглалтад оруулсан.	1 км-ээс доошгүй талбайд явган хүн, дугуйн зам байгуулна.	200.0	1,147.4 ДТХО 315.8 ДОНХС	Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 30327,19 мкв (12664,5 м урт) явган хүний зам талбайн засвар, шинэчлэх 11 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 1, 2, 3, 11 дүгээр хорооны 14 байршлын 9224.1 м.кв талбайн явган замын засвар, шинэчлэлтийн ажил бүрэн хэрэгжиж, 11, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны 10 байршлын 17298.09 м.кв (5.49 км) явган хүний шинэчлэх 3 төсөл арга хэмжээний ажлын явц 50 хувьтай он дамжин хэрэгжих бөгөөд 1, 2, 3, 6, 9, 15, 16, 19, 20 дугаар хорооны 10 байршлын 3805 м.кв (2.19 км) явган хүний замыг засварлаж шинэчлэх 3 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд байна. Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17, 22, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт 4.13 км дугуйн замын тохижилтын ажил хэрэгжиж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 22 дугаар хороо, "Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил"-ын хүрээнд 0.63 км урт (2990 м.кв) дугуйн зам, 2590 м.кв талбайд явган хүний зам шинээр тавьж, ашиглалтад оруулсан. 17 дугаар хороонд он дамжин хэрэгжиж буй Маршаллын гүүрнээс Зайсангийн гүүр хүртэл Туул голын далан дайруулах 2.4 км унадаг дугуйн зам, явган замын ажил суурийн тэгшилгээ хийгдсэн, бродюрь суурилуулах, далангаас буух 2 шатны цутгалтын ажил хийгдэн он дамжин хэрэгжихээр болсон.	100%
5.3.7 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагын автомат системд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	137	Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл өрхийн судалгааг гарган холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар цахилгаан, эрчим хүчинд холбоно.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	525	11, 12 дугаар хороонд цахилгааны хүчдэл сайжруулсан.	Шаардлагатай байршилд цахилгааны хүчдэл сайжруулсан байна.	-	173.2	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12, 13, 14 дүгээр хороонд цахилгааны хүчдэл сайжруулах 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд: Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хороонд 151 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах, цахилгааны шугам сүлжээнд холбох ажил хэрэгжиж дууссан. Улсын комисс акт баталгаажих шатанд, 12 дугаар хорооны Хайрхан хэсгийн 32 өрх цахилгааны хүчдэлийг сайжруулах, найдвартай эрчим хүчний эх үүсвэрт холбох ажлын явц 80 хувь, 13 дугаар хороонд хэрэгжих 4, 5, 6, 7-р хэсгийн 885 айл өрхийн "Цахилгааны хүчдэл сайжруулах ажил" зураг төсөл боловсруулах шатанд тус тус хэрэгжиж байна.	90%
Шаардагдах төсөв							22,178			4,500.0	2,188.2		
5.4 Хоггүй Хан-Уул													
5.4.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	138	Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021-2024	ТНААХ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Дүүргийн төсөв	100	-	Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна.	-	-	"Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрт 3 зорилт хүрээнд 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2023 онд 3 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. Дэд хөтөлбөрийн хүрээнд хог хаягдал цуглуулах, тэвэрлэх гэрээний загварыг шинэчлэн дүүргийн нийт 1235 аж ахуйн нэгж байгууллагатай шинээр гэрээ байгуулж, хяналт тавих зорилгоор дундын мэдээллийн сан /Google sheet/ үүсгэн 7 хоног бүр мэдээллийг шинэчилж байгаа бөгөөд 980 байгууллагын мэдээлэл бүртгэгдсэн. Мөн 685 ААНБ-ын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглалыг гэрээний хавсралтаар баталгаажуулж, Газар зүйн мэдээллийн систем (ArcGIS)-д бүртгэсэн. Япон улсын "SEC" компанийн удирдлагуудтай дүүргийн хог хаягдлын менежментийн чиглэлээр хамтран ажиллах санал солилцох, "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг танилцуулах уулзалт зохион байгуулсан. Хог хаягдал ашиглалтын талаар мэдлэг, мэдээлэл өгөх, дахивар хог хаягдал авах өдөрлөгийг нийт 500 гаруй иргэн, 20 гаруй сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуй нэгж, байгууллага хамруулан 2 удаа зохион байгуулж, дахин ашиглах боломжтой 13 төрлийн нийт 4974 кг хог хаягдлыг цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэсэн. Хуванцар дахин боловсруулах үйлдвэр эрхлэгч "Ти эм эл" ХХК-тай хамтран дүүргийн 234 байгууллага, СӨХ гэрээ байгуулж, 54,214 кг хуванцар нийлүүлж, дахин боловсруулсан. Мөн "Өгөөмөр өдөр" арга хэмжээнд төр, хувийн хэвшлийн 50 аж ахуйн нэгж, байгууллагын 440 гаруй иргэд оролцож дахин ашиглах боломжтой 30 гаруй нэр төрлийн 907 ширхэг (5 тн) эд зүйлсийг цуглуулж, зорилтот бүлгийн иргэдэд хүргүүлсэн.	70%
	139	Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулна.	2021-2024	ТНААХ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Дүүргийн төсөв	160	Дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан.	10-аас доошгүй удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан байна.	40.0	58.2	Дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 12 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 8125 аж ахуй нэгж байгууллага, 309 сууц өмчлөгчдийн холбоодын 15,600 хүн оролцож, 215,311 м.кв талбайгаас 451,8 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн. "Хаврын их цэвэрлэгээ" сарын аяны хүрээнд 115 автобусны буудал, 2,850 урт метр хайс хашлага, 205 авто замын тэмдэг тэмдэглэгээ, 26 хөшөө дурсгал, 455 спорт болон тоглоомын талбай, 226 хогийн сав, 210 сандлыг тус тус угааж цэвэрлэсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.4.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	140	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, талбайг тогтмол ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авна.	2021-2024	ТНААХ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Дүүргийн төсөв	600	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 126,854м2 гудамж, талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 150,000м2 гудамж талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.	150.0	229.0 НТХО	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/286 дугаар захирамжийн хүрээнд 8, 10, 12, 13, 14, 21 дүгээр хороонд 3375 тн үүсмэл хог хаягдал, өтөг бууцыг цэвэрлэж, 892 малын сэг зэмийг устгаж, 2500 м.кв талбай, 5, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт бохир хальсан болон хогийн цэгийн 15,000 м.кв талбай, гэр хорооллын 12099 нүхэн жорлон, 5732 бохирын цооног буюу 17500 кв талбайг ариутгаж, халдваргүйжүүлсэн. Мөн дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбайд хөрсний бохирдол, доройтлыг саармагжуулах ажлын хүрээнд 2, 5, 6, 7, 8, 12, 13, 20-р хороонд Нийслэлийн Байгаль орчны газраас мэргэжлийн байгууллага "Саблайм" ХХК-тай хамтран хөрсний бохирдолтой 14 цэгийг тогтоож, талбайн судалгаа хийж, 20-р хороо УСҮГ-ын харьяа Харгия урьдчилан цэвэрлэх байгууламжийн орчмын 3,9 га талбай, 12-р хороо Биокмбинат, 326-р цэргийн ангийн урд талын 0,4 га талбай, 13-р хорооны нутагт байрлах Шувуун фабрик, хогийн цэгийн 5,7 га нийт 3 байршлын хүнд металлын бохирдолтой 10 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. Нийт 117500 кв талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.	90%
5.4.2 Хог хаягдлын тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын авто машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	141	Хог хаягдлын тээврийн машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Улс, нийслэл дүүргийн төсөв	5,196	Хог тээвэрлэлтийн 3 байгууллагад 32 хог тээврийн машин ажиллаж байна.	Хог тээврийн 10-аас доошгүй автомашин худалдаж авна.	800.0	2063.5	Хоггүй Хан-Уул хөтөлбөрийн хүрээнд Хог тээврийн авто машины парк шинэчлэлтийн төсөл арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд: Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд он дамжин хэрэгжсэн "Хог тээврин авто машин худалдан авах" төсөл арга хэмжээний хүрээнд хог шахаж ачих зориулалттай Хьондай HD78, HD170 маркийн 11 автомашин, "Хог тээврийн авто машин худалдан авах төсөл арга хэмжээний Багц-1" ажлын хүрээнд Dong Feng ХО маркын 5 ширхэг задгай тэвштэй хог тээврийн машин худалдаж авч, нийт 16 авто машиныг хог тээврийн 4 байгууллагад хүлээлгэн хог тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн ажилласан. "Хог тээврийн авто машин худалдан авах төсөл арга хэмжээний Багц-2" ажлын хүрээнд хог тээврийн задгай тэвштэй 8 тн-ын даазтай цас хусагч нэмэлт төхөөрөмжтэй 7 автомашин худалдаж авах ажлын тендерийг 11 дүгээр сарын 22-нд зарласан.	100%
5.4.3 Гэр хорооллын айл өрхүүдийг үнс хадгалах савтай болгох, ангилан ялгах, тусад нь тээвэрлэх ажлыг зохион байгуулна.	142	Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	2021-2024	ТНААХ	Хог тээврийн үйлчилгээний ОНӨААТҮГ-ууд	Улс, нийслэл дүүргийн төсөв	-	Ажлын хэсэг байгуулагдсан.	Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	-	4.9	Гэр хорооллын айл өрхүүдийн тусд нь ангилсан үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хэрэгжүүлж байгаа үнс дахин боловсруулах үйлдвэр барих төсөлтэй хамтран ажиллахаар бэлтгэл ажил хангаж байна. Гэр хорооллын айл өрхүүдийг галлагаанаас гарсан үнсийг ангилан ялгах, угаарын хийн эрсдэлээс сэргийлэх зөвлөмжийг гэр хорооллын 1100 айл өрхөд тарааж, мэдээлэл хүргүүлсэн.	30%
Шаардагдах төсөв							6,056			990.0	2,355.6		
5.5 Инженерийн бэлтгэл арга хэмжээ													
5.5.1 Шинээр барих болон өргөтгөн шинэчлэх авто замын дагуу зам, талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулна.	143	Төсвийн хөрөнгөөр шинээр хийгдэх авто замыг борооны ус зайлуулах шугам сүлжээтэйгээр төлөвлөн хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	-		Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг байгуулсан байна.	672.9	519.8 ДТХО	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороо нисэхийн авто зам дагуу 762 урт метр "Борооны ус зайлуулах шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж, шугамын угсралтын дараах авто зам, явган хүний замыг бүрэн нөхөн сэргээсэн. Мөн Нисэхийн авто замын ус зайлуулах хуучин сувгийг далд шугам болгох ажлын хүрээнд 4 ширхэг шүүрт худаг гаргаж, ф300 мм-ийн голчтой 56 метр ган шугамыг угсрах, наадамчдын автозамын 430 метр урт ус зайлуулах шугам шинэчлэх, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамжны 497 метр урт ус зайлуулах шугам угсрах ажил тус тус хийгдсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.5.2 Үерийн хамгаалалтын далан сувгийг шинэчлэх болон барьж байгуулна.	144	Үер, усны аюулд өртдөг болон өртөх боломжтой бүсийн судалгааг гарган ус зайлуулах далан, сувгийг байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНААХ, ОБ		Улс, нийслэл, дүүрэг төсөв	100	-	Шаардлагатай байриилд ус зайлуулах суваг байгуулсан байна.			Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Нисэхийн авто зам дагуу 762 урт метр "Борооны ус зайлуулах шугам сүлжээний ажил"-ын барилга угсралтын ажил, дүүргийн Засаг даргын 2023 оны А/429 дүгээр захирамжийн дагуу 24-р хорооны Вива сити хорооллын ард 144 м.кв талбайд авто зам, үерийн даланг хүчитгэх ажил, 2023 оны А/484 дүгээр захирамжийн дагуу 7 дугаар хорооны Жаргалантын 18 дугаар гудамжинд 43 урт метр ус зайлуулах шуудуу хийж, гудамжийг зохист найрлагатай дайргаар засварлах ажлыг тус тус хэрэгжүүлсэн.	100%
5.5.3 Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг нарийвчлан тогтоож тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг нүүлгэн шилжүүлж, хамгаалалтын бүсийн газрыг албажуулна.	145	Үерийн аюултай бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	2021-2024	ТНААХ, ГЗБА, ОБ	ОБХ	Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	он зөвшөөрөлгүй бү	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.			Нийт шар усны үерт автах боломжтой эзэмших эрхийн гэрчилгээтэй 97 нэгж талбар, өмчлөх эрхийн гэрчилгээтэй 77 нэгж талбарын дэлгэрэнгүй судалгааг гаргаж НГЗБА-нд 2023 оны 3 дугаар сарын 19/216 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүүргийн хэмжээнд үерийн аюултай бүс болон үндны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй газар эзэмшиж, суурьшсан 4, 5, 12 дугаар хороодын нийт 226 өрхөд дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран гаргасан мэдэгдэх хуудас хүргүүлж, 22 хорооны нутаг дэвсгэр Туул гол дагуу үерийн бүсэд зөвшөөрөлгүй буусан 28 айл өрхийг 10 дугаар хорооны нутаг дэвсгэр рүү нүүлгэн шилжүүлсэн.	100%
Шаардагдах төсөв							100			672.9	519.8		
5.6 Усан хангамж, ариутгах татуурга													
5.6.1 Аж ахуйн нэгж, байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	146	Туул голын сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана.	2021-2024	ТНААХ				5 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус хаях зөвшөөрөл олгосон.	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, хяналт тавьж ажиллана.			Туул голын сав газраас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжаар "Промикс индустриал" ХХК-д, 2023 оны А/48 дугаар захирамжаар "Эко асфальт" ХХК-д, 2023 оны А/310 дугаар захирамжаар "Тедмент бетон зуурмаг" ХХК-д, 2023 оны А/320 дугаар захирамжаар "Чингис хааны хүрээ" ХХК-д хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, гэрээ байгуулагдсан.	100%
5.6.2 Ундны усны эх үүсвэрийн гүний худаг тоолуургүй айл өрх, аж ахуйн нэгжийг тоолууржуулж усны бодит хэрэглээг тооцно.	147	Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн "Ус ашиглах зөвшөөрөл" олгож гэрээ байгуулж, хяналт тавих, усны мэдээллийн санд бүртгэнэ.	2021-2024	ТНААХ				11 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус ашиглах зөвшөөрөл олгосон.	Ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэж, хяналт тавьж ажиллана.			Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2023 оны А/02 захирамжаар "Промикс индустриал" ХХК, А/542 захирамжаар "Нумт гүрэн" ХХК-д тус тус ус ашиглах зөвшөөрөл олгон гэрээ байгуулагдсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2023 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.6.3 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.	148	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улсын төсөв	-	Зайсан орчмын орон сууцнуудыг усан хангамжид холбох ажлын явц 30%-тай.	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	-	240.0 ДТХО 300.0 НОНХС	Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, хотын захиргааны шинэ барилгын хойд талаас Ярмагийн бохир усны насосны станц хүртэл 600 мм-ийн голчтой 3.4 км шугам, насос станцын угсралтын II ээлжийн ажил хийгдэж дууссан. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжлтээр 10 дугаар хороо, Морингийн давааны шинэ суурьшлын бүсээс Нисэхийн цэвэрлэх байгууламж хүртэл 200 – 400 мм-ийн голчтой 2.6 км урт бохир усны шугам угсралтын ажлыг "Набсан" ХХК, "ЧМ" ХХК, "Санжат" ХХК-иуд 95 хувьтай гүйцэтгэж, холбооны шугамын угсралт дууссан. Цахилгааны шугамыг Буянт-Ухаа дэд станцад холбосноор 1000 м3 усан санг ашиглалтад оруулна. Монголын Мянганы сорилтын сангаас дүүргийн 12, 13 дугаар хороодын нутаг дэвсгэрт "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр" төслийн хүрээнд 1000мм-н голчтой 25 км урт шугамын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Энэ онд 1.4 км шугамын ажил хийгдэж дуусаад байна. 3 дугаар хороо, Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтээр дулааны 3 дугаар цахилгаан станцаас ТК –1699 цэг хүртэлх насжилтын хугацаа дууссан 2ф800 мм-ийн голчтой 5а магистраль 667.8 метр дулаан болон уурын хос шугамыг 2ф1000 мм голчтой болгож өргөтгөн шинэчлэх ажил хийгдэж дууссан. 6 дугаар хороо, "Цэвэр агаар төсөл"-тэй хамтран дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хорооны нутаг дэвсгэр дэх төсөвт байгууллагуудыг инженер хангамжийн төвлөрсөн системд холбох гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил дууссан. 11 дүгээр хороо, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зайсангийн хэсгийг ус хангамжийн төвлөрсөн системд холбох 219 мм-ийн голчтой 3 км урт хос шугам, 500 м.куб багтаамжтай усан сангийн ажлыг "Баткомплект" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 100-300 мм-ийн голчтой 7.9 км урт шугам сүлжээний 3.9 км шугам сүлжээ буюу 70 хувийг БУМБОД ХХК гүйцэтгэж, үлдсэн усны шугам дагуу 4 айл чөлөөлөх шаардлагатай тул зогссон. Мөн Зайсангийн гүүрний засвар шинэчлэлтийн ажилтай уялдуулан ф219 мм-ийн голчтой 80 метр урт цэвэр усны цайрдсан шугамын ажил хийгдсэн.2024 оны улсын төсөвт үлдэгдэл хөрөнгө болох 4 тэрбум төгрөгийг тусгуулсан.	90%
5.6.4 Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна.	149	Смарт ажиллагаатай худаг байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	-	2-оос доошгүй смарт ажиллагаатай худгийг байгуулна.	-		Дүүргийн төсвийн 240 сая төгрөгийн хөрөнгөөр 11 дүгээр хороонд 1 худаг, 9 дүгээр хороонд 1 смарт худаг, 13 дугаар хороонд 1 худаг, 14 дүгээр хороонд 2 худаг нийт 5 гүний худгийн барилга угсралтын ажил дууссан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 10, 12, 13, 14 дүгээр хороодын 11 гүний худгийг засварлаж, ухаалаг төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байгаа бөгөөд 2023 ондоо багтаан худгийн барилгын дотор засал, смарт төхөөрөмж суурилуулах ажил бүрэн хийгдэж дуусна. 2024 онд худгийн барилгын фасад засварын ажлыг хэрэгжүүлнэ. Монголын Мянганы сорилтын сангаас дүүргийн 12, 13 дугаар хороодын нутаг дэвсгэрт "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр" төслийн хүрээнд 1000мм-н голчтой 25 км урт шугамын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Энэ онд 1.4 км шугамын ажил хийгдэж дуусаад байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилот төвшин 2023 он			Хэргэжилт	Хэргэжилтийн хувь
				Үндсэн	Хамтрагч				Хурах түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.6.5 Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож баталгаажуулна.	150	Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	2021-2024	ТНААХ, ГЗБА		Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	Яармагийн гүүрнээс маршалын гүүр хүртэлх онцгой хамгаалалтын бүсэд өртсөн 50 нэгж талбар, "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр"-ийн трасст өртсөн 109 нэгж талбарын судалгааг гаргасан.	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.			Дүүргийн 12 дугаар хороо Амралтын хэсэг буюу ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд дүүргийн Засаг даргын захирамжаар газар эзэмшиж байгаа 113 нэгж талбарын судалгааг гарган 2023 оны 19/108 дугаартай албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Үүнээс гадна "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр" бүтээн байгуулалтын ажлын трасст өртсөн тус дүүргийн 13, 12 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 109 нэгж талбарыг бүрэн чөлөөлсөн. Мөн ундны усны эх үүсвэрийн хориглолтын бүс, усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд дүүргийн Засаг даргын захирамжаар олгогдсон тус дүүргийн 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх 29 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг дүүргийн Засаг даргын 2023 оны А/507 дугаар захирамжаар хүчингүй болгож, газрын мэдээллийн сангаас хасалт хийсэн. Мөн 22 хорооны нутаг дэвсгэр Туул голын хамгаалалтын 50 метрийн бүсэд зөвшөөрөлгүй буусан 28 айл өрхийг 10 дугаар хорооны нутаг дэвсгэр рүү нүүлгэн шилжүүлснээр зөрчил 80% буурсан. Дүүргийн хэмжээнд үерийн аюултай бүс болон ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй газар эзэмшиж, суурьшсан 4, 5, 12 дугаар хороодын нийт 226 өрхөд дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран гаргасан мэдэгдэх хуудас хүргүүлсэн.	80%
5.6.6 Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээний машин механизмаар хангалт хийж засвар үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгаж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	151	Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНААХ		Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-		Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.			Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтээр 3 дугаар хороо, дулааны 3 дугаар цахилгаан станцаас ТК -1699 цэг хүртэлх насжилтын хугацаа дууссан 2Ф800 мм-ийн голчтой 5а магистраль 667.8 метр дулаан болон уурын хос шугамыг 2Ф1000 мм голчтой болгож өргөтгөн шинэчлэх ажил хийгдэж дууссан. "Цэвэр агаар төсөл"-тэй хамтран дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх төсөвт 6 байгууллагуудыг инженер хангамжийн төвлөрсөн системд холбох гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил дууссан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11 дүгээр хороо, Зайсангийн хэсгийг ус хангамжийн төвлөрсөн системд холбох 219 мм-ийн голчтой 3 км урт хос шугам, 500 м.куб багтаамжтай усан сангийн ажлыг "Баткомплект" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 100-300 мм-ийн голчтой 7.9 км урт шугам сүлжээний 3.9 км шугам сүлжээ буюу 70 хувийг БУМБОД ХХК гүйцэтгэж, үлдсэн усны шугам дагуу 4 айл чөлөөлөх шаардлагатай тул зогссон. Мөн Зайсангийн гүүрний засвар шинэчлэлтийн ажилтай уялдуулан Ф219 мм-ийн голчтой 80 метр урт цэвэр усны цайрдаан шугамын ажил хийгдсэн.2024 оны улсын төсөвт үлдэгдэл хөрөнгө болох 4 тэрбум төгрөгийг тусгуулсан. нийслэлийн төсвийн хөрөнгөөр 13, 14 дүгээр хороо, халаалтын зуухны хуучирч муудсан дулааны шугамыг хэсэгчлэн шинэчлэн солих шугам хоолойн угсралтын ажил бүрэн дууссан. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 13 дугаар хороонд хэрэглэгчдийн дулааны салбар шугам болон 1-5 дугаар байрны барилгын доторх шугам хоолойн, халаах хэрэгсэл, тоноглолуудыг шинэчлэх ажил хийгдэж дууссан.	100%
Шардагдах төсөв											540.0		
ТАВ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ							30,861				6,566.5	8,834.0	88%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ							229,197				44,713.9	51,956.1	90,4%

ТАНИЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХӨРӨНГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

БОЛОВСРУУЛЖ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАВИРСАН
МЭРГЭЖИЛТЭН

С.СНХБАЯР
Л.ОТГОНБАЯР
Н.АЛДАРМАА